2025

АЖЛЫН ЦАХИМ ТАЙЛАН

ЧИНБАТЫН

Ундрам

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
ДОКТОР, ДЭД ПРОФЕССОР

ГАРЧИГ

I. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

1. ТАНИЛЦУУЛГА
2. АЖЛЫН ХЭСЭГТ ОРЖ АЖИЛЛАСАН БАЙДАЛ
3. ХУУЛИЙН ТӨСӨЛ, УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ ӨРГӨН БАРЬСАН, ОРОЛЦСОН БАЙДАЛ

II. ТОЙРОГТОО ЭРГЭХ ХОЛБООТОЙ АЖИЛЛАЖ БАЙНА

1. СОЁЛ, СПОРТЫН САЛБАРТ
2. БОЛОВСРОЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ
3. ДЭД БҮТЭЦ, ХӨГЖЛИЙН СУУРЬ
4. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР ЭДИЙН ЗАСГИЙГ СОЛОНГОРУУЛНА
5. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖИЙН ХӨГЖИЛД
6. ГАДААД ХАРИЛЦАА
7. СУРГАЛТ, МЭДЭЭЛЭЛ
8. ХАНДИВ, ДЭМЖЛЭГ
9. ИРГЭДЭД НЭЭЛТТЭЙ ТӨРИЙН ОРДОН

III.МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

1. ТӨСВИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮР ӨГӨӨЖ БА БОДЛОГЫН ШИЛЖИЛТ
2. УЛСЫН ТӨСВИЙН БОДЛОГЫГ ТОЙРОГТОО ХЭРЭГЖҮҮЛСЭН НЬ (СЭЛЭНГЭ АЙМАГ,
3. ТӨВИЙН БҮС)

IV. ЯАМНЫ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОХ ҮР ДҮН

1. СОЁЛ, УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР
2. СОЁЛЫН ӨВИЙН ЧИГЛЭЛЭЭР
3. СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР
4. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР
5. ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР
6. ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

СОЁЛ, СПОРТ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт Монголчууд аа, Итгэл хүлээлгэсэн Сэлэнгэ нутгийн зон олон оо, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарын эрхэм хамт олон, түншүүд ээ!

Миний бие Улсын Их Хурлын гишүүн болон Засгийн газрын гишүүний хувиар 2025 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлангаа тоймлон хүргэж байна. 2025 онд миний бие Улсын Их Хурлын гишүүн болон Засгийн газрын гишүүний хувиар хэрхэн ажилласан товч тайлангаа өргөн барьж байна.

Өнгөрсөн жил миний хувьд хууль баталж, бодлого тодорхойлох үндсэн үүргээ гүйцэтгэхийн зэрэгцээ хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, иргэдийнхээ санал бодлыг сонсож, тулгамдсан асуудлыг газар дээр нь шийдвэрлэхийг зорьсон, төрийн бодлогыг бодит үр дүн болгосон онцгой жил байлаа. Та бүхний итгэл, дэмжлэгийн үр дүнд хамтдаа хийж хэрэгжүүлсэн ажил багагүй ч цаашид хийх ажил, зорилт арвин хэвээр байна.

УИХ-ын гишүүний хувиар бид өрхийн орлогыг дэмжих, эрүүл мэнд, боловсролын хүртээмжийг сайжруулах хууль тогтоомжуудыг батлуулахад төвлөрч ажиллалаа. Төрөлх Сэлэнгэ аймагтаа “Нэг баг - Нэг сургууль” төслийг хэрэгжүүлж, эмнэлгүүдээ нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах зэргээр иргэдийнхээ өдөр тутмын амьдралд шууд эерэгээр нөлөөлөх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудыг улсын төсвөөр амжилттай шийдвэрлүүллээ.

Харин Засгийн газрын гишүүн, салбарын Сайдын хувиар соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбартаа түүхэн гэж хэлж болохуйц дээд амжилтуудыг салбарынхантайгаа хамтдаа бүтээж чадлаа. Соёлыг зөвхөн өвлөн хадгалах бус, дэлхийд түгээн дэлгэрүүлэх бодлогын хүрээнд Монгол Улс түүхэндээ анх удаа ЮНЕСКО-гийн Дэлхийн өвийн хорооны гишүүнээр сонгогдож, Франц улсаас ховор олдворуудаа буцаан авч, “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалиар үндэснийхээ дархлааг дэлхийд таниулж чадлаа.

Аялал жуулчлалын салбарт түүхэн өсөлт гарч, 854 мянган жуулчин хүлээн авсан нь энэ салбарыг эдийн засгийн тогтвортой өсөлтийн чухал хөшүүрэг болгон хөгжүүлэх бидний зорилт биеллээ олж буйн илрэл юм. Спортын салбарт 3х3 сагсан бөмбөгийн эмэгтэй шигшээ баг маань Дэлхийн аваргаас мөнгөн медаль хүртэж эх орныхоо нэрийг дуурсгасны зэрэгцээ нийтийн биеийн тамирыг төлөвшүүлэх бодлогын шинэчлэлийг эхлүүллээ. Түүнчлэн залуучуудыг зөвхөн ирээдүйн бус, өнөөдрийн идэвхтэй оролцогч, шийдвэр гаргагчид хэмээн үзэж, тэднийг дэмжих шинэ шатны ажлуудыг хэрэгжүүлж байна.

Эдгээр ололт амжилт нь төр, хувийн хэвшил, уран бүтээлчид, тамирчид, залуучууд болон ард иргэд Та бүхний минь итгэл сэтгэл, хамтын хөдөлмөрийн үнэ цэнтэй үр дүн билээ.

Цаашид ч иргэдийнхээ итгэлийг хамгийн том хариуцлага хэмээн ухамсарлаж, эх орныхоо хөгжил дэвшил, нэр хүндийг улам өндөрт өргөхийн төлөө тууштай, чин сэтгэлээсээ зүтгэх болно.

Та бүхэндээ эрүүл энх, аз жаргал, амжилт бүтээлийн дээдийг хүсэн ерөөе.

Хүндэтгэсэн,
ЧИНБАТЫН УНДРАМ
Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн,
Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд

I

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

I.1 ТАНИЛЦУУЛГА

БОЛОВСРОЛ, МЭРГЭЖИЛ

- 1998 он: Нийслэлийн 23 дугаар дунд сургууль
- 1999 он: АНУ, "Terry Sanford" ахлах сургууль
- 2003 он: Их Британи, Лондон хот дахь Олон улсын Америкийн их сургуулийн Бизнесийн сургууль /Бакалавр/
- 2004 он: Их Британи, Лондон хот дахь Олон улсын Америкийн их сургуулийн Бизнесийн сургууль /Магистр/
- 2010 он: Япон Улс, Нагояагийн их сургуулийн Эдийн засгийн сургууль / Доктор/

АЖИЛЛАСАН БАЙДАЛ

- 2007-2008 он: Япон Улсын Нагояагийн их сургуулийн Эдийн засгийн сургуульд зочин судлаач
- 2010-2020 он: АНУ-ын Харвардын их сургуулийн Бизнесийн сургуулийн дэргэдэх Өрсөлдөх чадварын макро эдийн засгийн хүрээлэнгийн Монгол Улс дахь зохицуулагч
- 2010-2020 он: 2010-2020 он (МУИС-ийн удирдлага, академик чиглэлээр): МУИС-ийн Бизнес, Эдийн засгийн сургуульд профессороор багшлахын зэрэгцээ Бакалавр болон Сургалтын нэгдсэн албаны дарга, Захиргаа, дотоод хамтын ажиллагаа, Санхүү, төлөвлөлт хариуцсан Дэд захирлын албыг тус тус хашсан
- 2017-2020 он: Монгол Улсын Ерөнхий сайдын Эдийн засгийн бодлогын зөвлөлийн гишүүн
- 2020 оноос өнөөг хүртэл: Монгол Улсын Их Хурлын гишүүн (2020 болон 2024 оны ээлжит сонгуулиар улиран сонгогдсон)
- 2024-2025 он: Монгол Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга
- 2025 оноос: Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд

СОНГУУЛЬТ АЖИЛ

- 2017 оноос: Монголын эмэгтэй инженерүүд, технологичид, эрдэмтэд, математикчдын нэгдсэн байгууллагын (WSTEM) Удирдах зөвлөлийн гишүүн
- 2021 оноос: Олон улсын парламентын холбооны Эмэгтэй парламентчдын удирдах товчооны гишүүн
- 2025 оноос: Сэлэнгэ аймгийн Монгол Ардын Намын хорооны дарга
- 2026 оноос: Монгол Ардын Намын Удирдах зөвлөлийн гишүүн
- Мөн: "Прогрессив Альянс" (Progressive Alliance) олон улсын байгууллагын Удирдах зөвлөлийн гишүүн

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам нь 2020 оны УИХ-ын ээлжит сонгуулиар Сэлэнгэ аймаг (13 дугаар тойрог)-т МАН-аас нэр дэвшин 22,583 сонгогчийн итгэлийг хүлээж сонгогдсон бөгөөд 2024 онд дахин сонгогдон ажиллаж байна. Тэрбээр тайлант хугацаанд хууль тогтоох үйл ажиллагаанд дараах байдлаар идэвхтэй оролцлоо:

- 2025 оны УИХ-ын Хаврын ээлжит чуулганд: Нийт 82 өдөр үргэлжилсэн тус чуулганы нэгдсэн болон хороодын хуралдаанд оролцож, 66 хууль, 59 тогтоол хэлэлцэн батлахад ажиллав.
- МАН-ын бүлгийн үйл ажиллагаанд: Хаврын чуулганы хугацаанд УИХ дахь МАН-ын бүлэг 17 удаа хуралдаж 50 асуудал шийдвэрлэсэн бөгөөд гишүүний зүгээс иргэд, байгууллагаас ирүүлсэн 35 өргөдөл, санал хүсэлтэд хариу өгч, шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулсан байна.
- 2025 оны Намрын ээлжит чуулганд: Нийт ажлын 75 өдөр хуралдаж, 14 хууль, 37 тогтоол хэлэлцэн батлах үйл явцад идэвхтэй оролцлоо.
- МАН-ын бүлгийн үйл ажиллагаанд: Намрын чуулганы хугацаанд УИХ дахь МАН-ын бүлэг нийт 12 удаа хуралдаж, давхардсан тоогоор 33 хууль тогтоолын төсөл, бодлогын баримт бичиг, цаг үеийн тулгамдсан асуудлуудыг хэлэлцсэн байна.

I.2 АЖЛЫН ХЭСЭГТ ОРЖ АЖИЛЛАСАН БАЙДАЛ

Ажлын хэсгийн АХЛАГЧААР

- Хөдөө аж ахуйн даатгал: Хөдөө аж ахуйн даатгалын тухай анхдагч хуулийн төсөл боловсруулах.
- Боловсролын чанар: “2026 оныг Боловсролыг дэмжих жил” болгох Засгийн газрын тогтоолын хүрээн дэх Боловсролын чанарын ажлын дэд хэсэг.
- Сургуулийн орчин, эрүүл ахуй: Боловсролын тухай хуулийн (42.1 дэх хэсэг) сургалтын байгууллагын барилга, техник хэрэгсэл нь багш, сурагчдын онцлог, тусгай хэрэгцээ, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангаж буй эсэх хэрэгжилтийг хангах ажлын хэсэг.

Ажлын хэсэг, зөвлөл, бүлгийн ГИШҮҮНЭЭР

Боловсрол, шинжлэх ухааны салбарт:

- Ариун цэврийн байгууламж: Сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандартаар солих, санхүүжилтийг шийдвэрлэх (2021-2022 он).
- Багш нарын асуудал: Багшийн хомсдолыг бууруулах, үнэлэмжийг дээшлүүлэх, сургуулийн менежментийг сайжруулах санал боловсруулах (2024 он).
- Шинжлэх ухааны хууль эрх зүй: Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт болон ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслүүд.

Хууль эрх зүй, нийгэм, хөгжлийн бодлогын салбарт:

- Хөгжлийн бодлого: Монгол Улсыг 2025–2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах УИХ-ын тогтоолын төсөл.
- Нийгмийн халамж: Ахмад настны болон Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилт, асрамжийн газруудын үйл ажиллагааг хянан шалгах.

I.3 ХУУЛИЙН ТӨСӨЛ, УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ ӨРГӨН БАРЬСАН, ОРОЛЦСОН БАЙДАЛ

Доорх хуулийн төслүүдийг боловсруулахдаа салбарын судлаачид, орон нутгийн иргэд, бизнес эрхлэгчдийн оролцоог хангаж, олон улсын сайн туршлагад тулгуурлан ажиллалаа. Үүнд:

1. Эдийн засаг, бизнесийн орчныг сайжруулах чиглэлээр:
- **ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл (2024-2025 он):** ЖДҮ-ийг татварын бодлогоор дэмжиж, ажлын байрыг хадгалах, нэмэгдүүлэх.
- **Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай төсөл (2025 он):** Эмэгтэйчүүдийн бизнес эрхлэх, санхүүжилт авах боломжийг тэлж, өрхийн орлогыг өсгөх.
- **Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулга (2025 он):** Төр-хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулж, хувийн хэвшлийн эрх ашгийг хамгаалах.

2. Хөдөө аж ахуй, малчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр:
- **Бэлчээрийн тухай хуулийн төсөл (2025 он):** Бэлчээрийн талхлалтыг бууруулах, маргааныг хуулиар зохицуулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох.
- **Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай төсөл (2024-2025 он):** (38 гишүүний хамт өргөн мэдүүлсэн) Малчид хоршоо, холбоо хэлбэрээр нэгдэж, бүтээгдэхүүнээ үнэ цэнтэй борлуулах, эрсдэлийг хамтран давах эрх зүйн орчныг баталгаажуулах.

3. Хүний эрх, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн чиглэлээр:

- **Биеийн тамир, спортын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт (2025 он):** Нийтийн спортыг хөгжүүлэх, тамирчдын нийгмийн баталгааг хангах.
- **Хэлмэгдэгсдийг цагаатгах болон Нөхөн олговрын тухай хуулиуд (2024-2025 он):** Төрөөс учруулсан хохирол, нөхөн олговрын тогтолцоог өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан шударгаар шинэчлэх.
- **Харьяатын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт (2025 он):** Гадаад дахь монголчуудын эрх ашгийг хамгаалах, өндөр нарийн мэргэжилтнүүдийг эх орондоо татах.
- **Эко үйлдвэрлэлийг дэмжих нь (2025 он):** Зориулалтын бус хуванцар савны хэрэглээг халах зорилгоор “Усны эко сав” үйлдвэрлэх төслийг бодлогоор дэмжин ажиллалаа.

Цаашид ч сонгогдсон тойргийнхоо иргэдийн дуу хоолойг төрийн бодлогод тусгаж, шинжлэх ухаан, боловсрол, ногоон хөгжлийг дэмжих чиглэлээр хууль эрх зүйн орчныг сайжруулан, тойрогтоо бодит үр дүнтэй төслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх болно.

II

ТОЙРОГТОО ЭРГЭХ ХОЛБООТОЙ АЖИЛЛАЖ БАЙНА

II.1 СОЁЛ, СПОРТЫН САЛБАРТ

Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,327 м.кв талбай бүхий, 400 хүний суудалтай 2 давхар Соёлын төвийн барилгыг ашиглалтад оруулж хүлээлгэн өгөв. Мөн Сэлэнгэ аймгийн 17 сум, тосгоны соёлын төвүүдэд нэн хэрэгцээт 10 гаруй нэр төрлийн тоног төхөөрөмжийг шинэчилж хөрөнгө оруулалт хийлээ.

Тус суманд анх удаа дуу тусгаарлалт, дуугаралтын стандартыг бүрэн хангасан, орчин үеийн гэрэл, дуу, техникийн иж бүрэн тоног төхөөрөмжтэй зориулалтын Соёлын төв ашиглалтад орж байна. Ингэснээр орон нутгийн иргэд тав тухтай, дулаан, эрүүл ахуйн шаардлага хангасан орчинд соёл, урлагийн арга хэмжээнд тогтмол хамрагдах боломж бүрдэж байгаа юм.

Бид цаашид сумдын Соёлын төвүүдийг “Соёл, хөгжлийн төв” болгон үе шаттайгаар өргөжүүлэх бөгөөд иргэдийн соёлын боловсрол, олон нийтийн оролцоо, орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр үйл ажиллагааны агуулга, хамрах хүрээг тэлэх зорилт тавин ажиллаж байна.

II.2 БОЛОВСРОЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ

БАГИЙН БАГА СУРГУУЛЬ

Сонгогдсон тойргийнхоо бяцхан үрсийг гэртээ ойр, тав тухтай орчинд сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлэхийн тулд Боловсролын яам болон НҮБын Хүүхдийн Сан (UNICEF)-гийн хамтарсан "Нэг баг - Нэг сургууль" үндэсний төсөлд Сэлэнгэ аймгийн Мандал сумын Тарни (8 дугаар) багийг амжилттай хамруулж, бодит ажил хэрэг болголоо.

Тэрээр энэхүү төсөлд "ХААН" банкны хөрөнгө оруулалтыг орон нутагтаа татаж чадсанаар 2026 оны 1 дүгээр сард 75 хүүхдийн багтаамжтай шинэ бага сургуулийг ашиглалтад оруулаа.

Уг сургууль нь дулаан алдагдалгүй, сэргээгдэх эрчим хүчтэй орчин үеийн инженерийн шийдэлтэй бөгөөд өндөр хурдны интернэт, цахим ангиар бүрэн тоноглогдсон. Ингэснээр алслагдсан багийн хүүхдүүд өвлийн хүйтэнд холын зам туулахгүйгээр олон улсын стандартад нийцсэн чанартай боловсролыг тэгш хүртэх боломжтой болж байна.

Тус төслийн хүрээнд улсын хэмжээнд нийт 5 байршилд багийн сургууль ашиглалтад орсны нэг нь ийнхүү Сэлэнгэ аймагт сүндэрлэсэн юм.

Нийт баригдсан 5 сургуулийн байршлыг дараалаар нь жагсаавал:

- Ховд аймгийн Үенчийн отряд (ХААН Банкны санхүүжилтээр)
- Увс аймгийн Боршоо боомт (ХААН Банкны санхүүжилтээр)
- Төв аймгийн Батсүмбэр сумын Цогт-Өндөр баг (Номин Холдинг ХХК-ийн санхүүжилтээр 3 дахь сургууль болж нээгдсэн)
- Сэлэнгэ аймгийн Мандал сумын Тарни баг (ХААН Банкны санхүүжилтээр)
- Төв аймгийн Батсүмбэр сумын Үдлэг баг (ХААН Банкны санхүүжилтээр 5 дахь нь болж нээгдсэн)

БОЛОВСРОЛЫН ОРЧИН БА АЦБ (Ариун цэврийн байгууламж)

- Улсын Их Хурлын эмэгтэй гишүүдийн хамтаар улсын хэмжээний төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны гадаа байрладаг 819 модон жорлонг орчин үеийн стандартын шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжтай болгох саналыг гаргасан. Улмаар уг ажлын санхүүжилт болох 100.0 тэрбум төгрөгийг нийгмийн хариуцлагын хүрээнд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аар гаргуулахаар шийдвэрлүүлж, одоогоор ажлын явц 85 хувьтай байна.







- Сэлэнгэ аймгийн Мандал сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль болон Хэрх тосгоны Ерөнхий боловсролын сургуулиудад хувийн хөрөнгө оруулалтаар орчин үеийн стандартад нийцсэн биеийн тамирын заал барьж хүлээлгэн өглөө.
- 2025 оны 4 дүгээр сард Сэлэнгэ аймгийн Мандал сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн барилгын ажилд шаардлагатай 3.9 тэрбум төгрөгийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлсэн.



БОЛОВСРОЛЫН САЛБАРТ ШИНЖЛЭХ УХААНЫ ДОВТОЛГОО

- Орон нутгийн багш нарын мэдлэг, ур чадварыг дэлхийн түвшинд хүргэх, олон улсын шилдэг туршлагаас суралцах боломжийг бүрдүүлэх зорилгоор Сэлэнгэ аймгийн багш нарын төлөөллийг Япон Улсын Нагояагийн их сургуулийн “Нобелийн шагналтнуудын хөтөлбөр”-т амжилттай хамруулаа. Хөтөлбөрт хамрагдсан багш нар дэлхийн шинжлэх ухааны шилдэг эрдэмтдийн өлгий нутагт зочилж, байгалийн шинжлэх ухаан, технологийн (STEM) сургалтын дэвшилтэт арга зүй, орчин үеийн боловсролын чиг хандлагаас биечлэн туршлага судалсан юм.

- Энэхүү бодлого, санаачилгын бодит үр дүн гарч, туршлага судлах аяллаас олж авсан мэдлэгээ ажил хэрэг болгон Сэлэнгэ аймгийн Сайхан сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн захирал С.Ичинхорлоо “Байгалийн шинжлэх ухааны нээлттэй бичил музей”-г санаачлан байгуулж, хүүхдүүдийн танин мэдэхүйг тэлэх, туршиж судлах, дүгнэлт хийх чадварыг хөгжүүлэх шинэлэг орчныг бүрдүүлсэн нь олон улсын сайн туршлагыг орон нутагтаа нутагшуулж, боловсролын чанарыг шинэ шатанд гаргасан бодит үр өгөөжтэй алхам болгосонд баяртай байна.

- Сэлэнгэ аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 483 багшид дунд оврын 15.6 инчийн Chromebook компьютерийг хүлээлгэн өгсөн бөгөөд энэ онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 733 багшийг зөөврийн компьютертэй болгохоор шийдвэрлэлээ.

- Сэлэнгэ аймгийн сум, тосгодын 14 цэцэрлэг болон Дархан-Уул аймгийн 15 дугаар сургуулийн багшийн хөгжлийн төвд нэн шаардлагатай зөөврийн компьютерүүдийг шийдвэрлэн хүлээлгэн өглөө.

ЭРҮҮЛ БИЕД САРУУЛ УХААН

- Сэлэнгэ аймгийн Мандал суманд ажиллах үеэрээ аймгийн Засаг даргатай хамт сумын Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаатай танилцаж, хүүхдийн тасагт нэн шаардлагатай байсан 44.7 сая төгрөгийн өртөг бүхий 14 нэр төрлийн тоног төхөөрөмжийг шийдвэрлэн хүлээлгэн өглөө. Уг хөрөнгө оруулалтад нярайн дулаацуулах ширээ, нярайн болон өвчтөний функциональ ор, хяналтын болон зөөврийн мониторууд, дуслын автомат шахуурга зэрэг эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай дэвшилтэт тоног төхөөрөмжүүд багтсан бөгөөд шууд ашиглалтад оруулсан нь орон нутгийн бяцхан үрсэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг эрс сайжруулав.

- Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлэгт сэргээн засах тусламж үйлчилгээний үйл ажиллагааг дэмжих зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн сэргээх танхимд 16 нэр төрлийн 40 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг хувийн хөрөнгөөр шийдвэрлэв. Мөн тус эмнэлгийн сантехникийн их засварт шаардагдах 3.2 тэрбум төгрөгийг улсын төсөвт тусгуулан засварыг бүрэн хийж гүйцэтгүүллээ.

- Төв аймгийн Угтаалцайдам сумын иргэдийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг дэмжих зорилгоор сумын Эрүүл мэндийн төвд нэн шаардлагатай байсан орчин үеийн “Зөөврийн ЭХО аппарат”-ыг шийдвэрлэн хүлээлгэн өглөө.
- Өсвөр үе, залуучуудын дунд эрүүл мэндэд эерэтэй, эко спортыг хөгжүүлэх зорилгоор Сэлэнгэ аймгийн унадаг дугуй сонирхогчдын “Мөнгөн хэгээс” холбооны үйл ажиллагааг дэмжиж, дугуйн спортыг орон нутагт дэлгэрүүлэхэд идэвхтэй хамтран ажиллалаа.

- Уламжлал болгон зохион байгуулдаг “Сэлэнгэ марафон” тэмцээнийг амжилттай зохион байгуулж 4 мянга гаруй иргэдийг хамруулав.

- 2025 оны 12 дугаар сард оюутан залуусын “Сэлэнгийн оюутан залуус-2025” спортын наадмыг анх удаа Улаанбаатар хотод зохион байгуулж, 300 гаруй оюутан залуусыг хамруулаа.

II.3 ДЭД БҮТЭЦ, ХӨГЖЛИЙН СУУРЬ

Инженерийн дэд бүтэц:

БАЯНГОЛ СУМАНД ШИНЭ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖ

Улсын төсвийн 4.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сэлэнгэ аймгийн Баянгол суманд шинэ цэвэрлэх байгууламж барих төслийг эхлүүлж, барилга угсралтын ажилд орлоо.

Тус байгууламж нь байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологиор тоноглогдох бөгөөд хоногт 250 м^3 бохир усыг бүрэн боловсруулж, 90-99 хувийн түвшинд цэвэршүүлэх хүчин чадалтай байх юм. Төслийн гүйцэтгэгчээр “Алтайн үндэс констракшн” ХХК шалгарсан бөгөөд 2026 оны 3 дугаар улиралд багтаан бүрэн ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Энэхүү бүтээн байгуулалт ашиглалтад орсноор Баянгол сумын иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах таатай нөхцөл бүрдэхээс гадна бүс нутгийн экологийн тэнцвэрт байдлыг хамгаалах, хөрс, усны нөөцийн бохирдлыг бууруулах чиглэлд бодитой ахиц дэвшил авчрах онцгой ач холбогдолтой юм.

АЛТАНБУЛАГИЙН ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН ӨРГӨТГӨЛ

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд байрлах Чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн өргөтгөлийн ажлыг 2022 оны Улсын төсөвт тусгуулан, 15.6 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 2022–2025 онд үе шаттайгаар амжилттай хэрэгжүүлж байна. Өнөөдрийн байдлаар төслийн гүйцэтгэл 99 хувьтай байна.

Төслийн хүрээнд Сүхбаатар 110/35/6 КВ-ын дэд станцын хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлж, Сүхбаатар–Алтанбулаг чиглэлийн 35 КВ-ын 18 км урт цахилгаан дамжуулах агаарын шугамын утсыг (АС50 маркийн утсыг АС150 болгон) бүрэн шинэчилж, дамжуулах чадварыг эрс сайжруулаа.

Энэхүү дэд станц болон шугам сүлжээний өргөтгөл бүрэн ашиглалтад орсноор

Алтанбулаг сумын цахилгаан хангамжийн найдвартай байдал дээшилж, Чөлөөт бүсийн үйл ажиллагаа, худалдаа үйлчилгээ тэлж хөгжих эдийн засгийн таатай нөхцөл бүрдэх онцгой ач холбогдолтой юм.

Авто замын бүтээн байгуулалт:

ХУШААТ СУМЫГ ДАРХАН-СЭЛЭНГИЙН АВТО ЗАМТАЙ ХОЛБОХ 16.9 КМ ХАТУУ ХУЧИЛТТАЙ ЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

Сэлэнгэ аймгийн Хушаат сумын төвийг Дархан-Сэлэнгийн авто замтай холбох хатуу хучилттай авто замын бүтээн байгуулалтын ажлын явцтай газар дээр нь очиж танилцлаа. Өнгөрсөн онд эхлүүлсэн тус замын ажлын үргэлжлэл 13.6 тэрбум төгрөгийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар амжилттай хэрэгжиж байна.

Төслийн хүрээнд 2025 онд нийт 16.9 км урттай авто замын далангийн ажлыг бүрэн гүйцэтгэж байгаа бөгөөд 2026 онд хатуу хучилт хийж, эцсийн байдлаар ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Энэхүү хатуу хучилттай зам ашиглалтад орсноор орон нутгийн иргэд найдвартай, аюулгүй, тав тухтай зорчих нөхцөл бүрдэхийн зэрэгцээ газар тариалангийн бүс нутгийн ложистик сайжирч, эдийн засаг, нийгмийн хөгжилд онцгой чухал хувь нэмэр оруулах юм.

II.4 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР ЭДИЙН ЗАСГИЙГ СОЛОНГОРУУЛНА

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын нутаг, Бүрэнхаан уулын бэл, Ивэн голын хөндийд орших түүх, соёлын хосгүй үнэт дурсгал болох Амарбаясгалант хийд орчмыг “Улсын аялал жуулчлалын бүс” болгон батлууллаа. Энэхүү шийдвэртэй уялдуулан тус бүсэд байгальд ээлтэй хог хаягдлын менежментийг нэвтрүүлж, хог шатаах зориулалтын 4 тоннын багтаамжтай бичил зуухыг хувийн хөрөнгөөр шийдвэрлэж өгсөн нь эдийн засаг, байгаль орчин, нийгэм-соёлын өндөр ач холбогдолтой цогц арга хэмжээ болов.

Аялал жуулчлал хөгжиж, хүн амын хөдөлгөөн ихсэхийн хэрээр ил задгай хог хаягдал олширч, хөрсөнд шингэн улмаар Ивэн голын усыг бохирдуулах эрсдэл нэмэгддэг. Тиймээс хог хаягдлын оновчтой шийдлийг нэвтрүүлсэн нь Ивэн голын сав газар, түүний хөндийн онгон дагшин байгаль, экосистемийг унаган төрхөөр нь хамгаалан үлдэх хамгийн зөв бөгөөд бодит алхам юм.

ЦААШИД:

- **Эдийн засаг, дэд бүтцийн хөгжил:** Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт татах хууль эрх зүйн баталгаа болж, зам, цахилгаан зэрэг дэд бүтцийн хөгжлийг хурдасгахын зэрэгцээ орон нутгийн иргэдийн орлого, ажлын байрыг бодитоор нэмэгдүүлнэ.
- **Байгаль орчны хамгаалал (Эко-туризм):** Хог хаягдлын асуудлыг тухай бүрд нь шийдвэрлэснээр хөрс, усны бохирдлоос урьдчилан сэргийлж, Ивэн голын хөндийн экологийн тэнцвэрт байдлыг хамгаална.
- **Түүх, соёлын өвийн хадгалалт:** XVIII зууны түүхэн дурсгалт газрыг доройтлоос хамгаалах, сэргээн засварлах болон ЮНЕСКО-ийн Дэлхийн өвд бүртгүүлэх үйл явцад чухал түлхэц болно.

II.5 ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖИЙН ХӨГЖИЛД

Сэлэнгэ аймгийн сумдад тулгамдаж байсан хэд хэдэн чухал асуудлуудыг шийдвэрлэгдлээ. Үүнд:

- **ЦАГААННУУР СУМАНД:** Онцгой байдлын эрэн хайх, аврах салбар шинэ байртай болж, гамшгийн үед ард иргэдэд цаг алдалгүй туслах нөхцөл бүрдлээ. Мөн малчдын хөдөлмөрийг дэмжих, эрүүл хүнсээр хангах зорилгоор Мал эмнэлгийн итгэмжлэгдсэн лаборатори үүдээ нээлээ.



- **САНТ СУМАНД:** Тус суманд Барилгын цэргийн анги шинээр байгуулагдсанаар орон нутгийн бүтээн байгуулалт хурдасч байна. Мөн олон жил сул зогсож, зориулалтаар нь ашиглахгүй байсан МСҮТ-ийн барилгыг эдийн засгийн эргэлтэд оруулж, төрийн хөрөнгийн үр өгөөжийг сайжруулав.
- **ЕРӨӨ СУМАНД:** Байгаль орчноо хамгаалах нь бидний нэн тэргүүний зорилт! Энэ хүрээнд Ерөө суманд хууль бусаар алт олборлож, байгаль экологид ноцтой хохирол учруулж байсан 4 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг хуулийн дагуу бүрэн таслан зогсоолоо.

Хөгжил рүү тэмүүлсэн, хариуцлагатай, аюулгүй Сэлэнгэ аймгийн төлөөх ажлууд үргэлжилсээр байна.

ОЛОН УЛСЫН СТАНДАРТАД НИЙЦСЭН МАЛ ЭМНЭЛГИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ:

Азийн хөгжлийн банкны 4.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сэлэнгэ аймагт 19 нэр төрлийн шаардлагыг бүрэн хангасан, олон улсын стандартад нийцсэн “Мал эмнэлгийн итгэмжлэгдсэн лабораторий” шинээр ашиглалтад орлоо.

Олон улсын стандартад нийцсэн энэхүү лаборатори байгуулагдсанаар орон нутагт дараах бодит боломжууд бүрдэж байна.

- Мал, амьтны бүх төрлийн халдварт өвчний шинжилгээг олон улсын түвшинд, цаг алдалгүй хийх;
- Импортоор орж ирж буй амьд малын эрүүл мэндэд өндөр хяналт тавих;
- Гадаад зах зээл рүү амьд мал, малын гаралтай бүтээгдэхүүн экспортлоход шаардлагатай шинжилгээ, баталгаажуулалтыг орон нутагтаа шууд хийх.

Тус лабораторийн үйл ажиллагаа нь бүс нутгийн хэмжээнд малын өвчинтэй тэмцэх чадавхыг эрс нэмэгдүүлж, хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх, улмаар малчдын орлогыг өсгөж, гадаад худалдааг өргөжүүлэхэд онцгой ач холбогдолтой бүтээн байгуулалт боллоо.

САНТ СУМАНД ИВЭН ГОЛЫН ДАЛАН, ХӨВ ЦӨӨРМИЙГ СЭРГЭЭХ

Сэлэнгэ аймгийн Сант сумын иргэдийн олон жил хүсэн хүлээсэн Ивэн голын боомт, сэтэрсэн даланг сэргээх амлалт ийнхүү бодит ажил хэрэг болж, улсын төсвийн 2.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар амжилттай бүтээн байгуулж дууслаа. Анх 1952 онд байгуулагдаж, 1960-аад онд сэтрэн, түүнээс хойш сэргээх хэд хэдэн оролдлого хийсэн ч амжилтгүй болж байсан уг даланг “MWT” ХХК гурван жилийн хугацаанд мэргэжлийн өндөр түвшинд, бат бөх чанартайгаар барьж ашиглалтад оруулаа.

Энэхүү хөв цөөрөм болон далангийн байгууламж ашиглалтад орсноор орон нутгийн хөгжилд дараах бодит үр өгөөжийг бий болгож байна:

- Орон нутгийн мал аж ахуй, газар тариалангийн усны найдвартай хэрэгцээг хангах;
- Үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлж, авран хамгаалах;
- Өвөл, зуны аялал жуулчлал, загас үржүүлэг, загасчлалыг хөгжүүлэх;
- Цаашид бага оврын усан цахилгаан станц (УЦС) байгуулан ажиллуулах суурь нөхцөлийг бүрдүүлэх.

Энэ нь байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалахын зэрэгцээ сумын эдийн засгийг солонгоруулах, иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн стратегийн онцгой ач холбогдолтой томоохон хөрөнгө оруулалт боллоо.

II.6 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР ЭДИЙН ЗАСГИЙГ СОЛОНГОРУУЛНА

1. БНХАУ-ын Шаньдун мужийн Чиндао хотноо зохион байгуулагдсан Шанхайн хамтынажиллагааны байгууллага (ШХАБ)-ын 5 дахь удаагийн Эмэгтэйчүүдийн форумд амжилттай оролцсон.

Энэ удаагийн форум нь “Цахимжуулалтаар дамжуулан эмэгтэйчүүдийн эдийн засгийг чадавхжуулах нь” болон “ШХАБ-ын хамтын хувь заяаны нийгэмлэгийн төлөө эмэгтэйчүүдийн хүчийг нэгтгэх нь” гэсэн үндсэн сэдвийн дор болж өнгөрөв. Тус арга хэмжээнд ШХАБ-ын гишүүн болон ажиглагч орнуудын 150 гаруй эмэгтэй манлайлагчид, төрийн өндөр албан тушаалтнууд хуран чуулсан юм.

Форумын үеэр бүс нутгийн хэмжээнд эмэгтэйчүүдийн нийгэм-эдийн засаг дахь манлайлал, шинжлэх ухаан, технологийн инновацад эмэгтэйчүүдийн тэгш оролцоог хангах асуудлаар төлөөлөгчидтэй уулзалт хийж, туршлага солилцов.

Түүнчлэн тэрээр Хятадын олон улсын CGTN телевизэд тусгайлан ярилцлага өгсөн бөгөөд уг ярилцлагадаа өнөөгийн Монголын эмэгтэйчүүдийн өмнө тулгамдаж буй сорилтууд, тэдгээрийг шийдвэрлэх гарц, мөн дижитал эдийн засаг дахь эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, сайн туршлагыг олон улсын үзэгчдэд танилцуулсан нь онцлох үйл явдал боллоо.

Цахим хөгжлийн эрин үед эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн хараат бус байдлыг технологиор дэмжих олон улсын чиг хандлагатай хөл нийлүүлэх, олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэхэд энэхүү форум чухал ач холбогдолтой байв.

2. Энэтхэг улсын Телангана мужид зохион байгуулагдсан олон улсын улс төрийн намуудын нэгдэл “Прогрессив Альянс” (Progressive Alliance)-ын чуулга уулзалтад дэлхийн 74 орны 400 гаруй төлөөлөгчдийн хамт Монгол Улсаа төлөөлөн оролцлоо.

Энэ удаагийн чуулган “Дэлхийн шударга ёсыг бий болгох” ерөнхий сэдвийн дор өрнөсөн бөгөөд миний бие тус байгууллагын Удирдах зөвлөлийн гишүүний хувиар “Жендэрийн шударга ёс ба ирээдүй” сэдэвт хэлэлцүүлэгт панелистаар оролцож, өөрийн байр суурыа илэрхийллээ.

II.7 СУРГАЛТ, МЭДЭЭЛЭЛ

- Сэлэнгэ аймгийн сурагчдыг БНСУ-д аялуулан сургалтад хамруулах төслийн хүрээнд аймгийн 2 сургуулийн захирлыг БНСУ-д сургагч багшаар бэлтгэлээ. Ингэснээр хүүхдүүд өвөл, зуны амралтаараа БНСУ-д богино хугацааны сургалтад хамрагдан хэл, соёл, шинжлэх ухааны мэдлэгээ дээшлүүлэх боломжийг нээв.
- Дархан хотод Биеийн тамир спортын удирдах ажилтны улсын зөвлөгөөнийг орон нутагт анх удаа томоохон хэмжээнд зохион байгуулав. Монголын анхны “Спорт инвестмент” арга хэмжээг зохион байгуулж хувийн хэвшилтэй хамтран хэлэлцүүллээ. Түүнчлэн сумдын Засаг дарга, ИТХ-ын дарга нар болон хилийн цэргийн албан хаагчдыг Улаанбаатар хотод шат дараатай сургалтуудад хамруулсан.

II.8 ХАНДИВ, ДЭМЖЛЭГ

ГАМШГИЙН ҮЕИЙН ТУСЛАМЖ, ХҮМҮҮНЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тойргийнхоо иргэд, малчдад байгалийн давагдашгүй хүчин зүйл, гамшиг ослын үед цаг алдалгүй бодит тусламж үзүүлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр дараах ажлуудыг хэрэгжүүллээ.

1. **Цас зудын хүндрэлийг даван туулах арга хэмжээ (2026 оны 1 дүгээр сар)** Улсын хэмжээнд цас ихтэй, өвөлжилт, хаваржилт хүндэрсэн цаг үед Сэлэнгэ, Дархан-Уул аймагт биечлэн ажиллаж, гамшгийн хохирлыг багасгах, малчдын амьжиргааг дэмжих зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Үүнд:

- **Техник, шатахууны дэмжлэг:** Зудын эрсдэл өндөртэй, зам даваа хаагдсан шаардлагатай сумдад цас цэвэрлэх, зам гаргах ажилд зориулан техник болон шатахууны тусламж үзүүлэв.
- **Өвс, тэжээлийн тусламж:** Малчдад мал сүргийг онд мэнд оруулах, хорогдлыг бууруулах зорилгоор нэн шаардлагатай өвс, тэжээлийн дэмжлэгийг шууд олголоо.
- **Техникийн шийдэл:** Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхаан тосгоны иргэдэд гамшгийн бэлэн байдлыг хангах, цас зудын хүндрэлийг хохирол багатай даван туулахад нь зориулж олон үйлдэлт хүнд оврын техник буюу “Ковш” (ачигч) машиныг бүрэн шийдвэрлэж, хүлээлгэн өгөв.

2. **Гал түймрийн гамшигт өртсөн өрхүүдэд үзүүлсэн тусламж**

- 2025 оны 5 дугаар сард гарсан гал түймрийн улмаас Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн, Хушаат, Ерөө, Цагааннуур сумдад орон гэр, эд хөрөнгөө алдсан 6 өрхөд Монголын Улаан загалмайн нийгэмлэг (МУЗН)-тэй хамтран хүмүүнлэгийн тусламж, эд материалын бодит дэмжлэг үзүүлж, иргэдийн амьдралыг хэвийн үргэлжлүүлэхэд туслалцаа үзүүлсэн.

II.9 ИРГЭДЭД НЭЭЛТТЭЙ ТӨРИЙН ОРДОН

Сонгогч, иргэдтэйгээ байнгын эргэх холбоотой ажиллах зорилтын хүрээнд Төрийн ордонд нийт 48 удаагийн уулзалт зохион байгуулж, иргэдийнхээ санал хүсэлтийг сонсож, төрийн бодлогод тусган ажиллалаа. Мөн салбартаа манлайлж, хөдөлмөр зүтгэлээ төрдөө үнэлүүлсэн иргэдэд төрийн дээд одон, медаль гардуулах хүндэтгэлийн арга хэмжээг 19 удаа зохион байгуулав.

Түүнчлэн бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулсан түүхэн хувь нэмрийг нь өндрөөр үнэлж, Төв аймгийн Сэргэлэн сум болон Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумыг тус тус Төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор шагнуулах үйлсийг амжилттай уламжлан шийдвэрлүүллээ.

III

МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ НЭГДСЭН ТӨСӨВ БА ТОЙРГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

III.1 ТӨСВИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮР ӨГӨӨЖ БА БОДЛОГЫН ШИЛЖИЛТ

Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсөв нь төрийн оролцоог хумьж, хувийн хэвшлийг дэмжих, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах суурь бодлогод чиглэсэн. “Данхар төрийг хумих” бодлогын хүрээнд төрийн үйл ажиллагааны урсгал зардлыг 6-12.8 хувиар, тоног төхөөрөмжийн зардлыг 50 хүртэл хувиар танаж, суларсан эх үүсвэрийг зам, тээвэр, дэд бүтцийн нэн шаардлагатай төслүүдэд төвлөрүүллээ.

Эдийн засгийн өсөлтийг өрх бүрд хүргэх зорилтын хүрээнд нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэндийн салбарт томоохон хөрөнгө оруулалт хийгдэв. Тухайлбал, багш нарын цалинг 50 хувиар, эмч, эмнэлгийн ажилтнуудын цалинг 15 хувиар, ахмад настны тэтгэврийг 8.6 хувиар тус тус нэмэгдүүлж, иргэдийн өдөр тутмын худалдан авалтад төлсөн НӨАТ-ын буцаан олголтыг (худалдан авалтын үнийн дүнгээс хамааран 50-100% хүртэл) шатлалтайгаар өсгөх зохицуулалтыг нэвтрүүлсэн нь өрхийн орлогыг бодитоор өсгөх эдийн засгийн чухал хөшүүрэг боллоо.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

III.2 УЛСЫН ТӨСВИЙН БОДЛОГЫГ ТОЙРОГТОО ХЭРЭГЖҮҮЛСЭН НЬ (СЭЛЭНГЭ АЙМАГ, ТӨВИЙН БҮС)

УИХ, Засгийн газрын гишүүний хувиар улсын төсвийн дээрх шинэчлэл, эдийн засгийн өгөөжийг өөрийн сонгогдсон тойрог болох Сэлэнгэ аймаг болон Төвийн бүсийн иргэдийн амьдралд бодитоор хүргэх, орон нутгийн хөгжлийг хурдасгахад онцгойлон анхаарч дараах хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтуудыг төсөвт тусгуулан хэрэгжүүлж байна.

Улсын төсвөөс багш, эмч нарын цалинг нэмэгдүүлэх суурь бодлогын зэрэгцээ орон нутагт ажиллах, сурах орчныг сайжруулахад чиглэв.

- **Боловсролын хүртээмж:** Алслагдсан багийн хүүхдүүдийг гэртээ ойр сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлэх “Нэг баг - Нэг сургууль” төслийг хэрэгжүүлж, Сэлэнгэ аймгийн Мандал сумын Тарни багт орчин үеийн бага сургууль ашиглалтад оруулаа. Мөн аймгийн 30 сургуулийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар лабораторитой болгож, Мандал сумын 2 дугаар сургуулийн барилгад 3.9 тэрбум төгрөгийг шийдвэрлүүлэв.
- **Эрүүл мэндийн шинэчлэл:** Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлгийн сантехникийн их засварт 3.2 тэрбум төгрөг төсөвлөж, аймгийн төв болон Мандал сумын эмнэлгийг Компьютер томограф (CT) аппараттай болгосноор иргэд хот руу явахгүйгээр орон нутагтаа нарийн оношилгоо хийлгэх боломж бүрдлээ.

Төсвийн үр ашгийг нэмэгдүүлж, бүтээн байгуулалтад чиглүүлэх бодлогын хүрээнд хөдөө аж ахуйн “Алтан гурвалжин”-г холбох стратегийн ач холбогдолтой төслүүдийг эхлүүлэв.

- **Авто замын сүлжээ:** Түшиг сумаас Зэлтэрийн боомт хүртэлх 130 км, Хушаат сумаас Дархан-Сэлэнгийн замтай холбогдох 16.9 км, Ерөө-Бугант чиглэлийн 80 км болон Амарбаясгалант хийд хүртэлх 45 км хатуу хучилттай замын ажлуудыг эрчимжүүллээ.
- **Инженерийн шугам сүлжээ:** Сэлэнгэ аймгийн 3000 гаруй өрх, аж ахуйн нэгжийг дулаанаар хангадаг “Сэлэнгэ Энерго”-гийн дулааны алдагдлын татаасыг төсөвт суулгаж, Баянгол сумын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх хөрөнгө оруулалтыг шийдвэрлэлээ.

Төрийн үйлчилгээг сайжруулж, орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр:

- **Аялалжуулчлалынбүс:** Амарбаясгалант хийд орчмыг “Улсын аялал жуулчлалын бүс”-ээр батлуулж, байгаль орчинд ээлтэй хог хаягдлын менежментийг нэвтрүүллээ. Мөн Дархан хотод зохион байгуулсан гурван улсын сайд нарын хурлаар “Цайны зам” авто аяллыг эхлүүлэв.

СЭЛЭНГЭ АЙМАГТ 2026 ОНД

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ

ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ

2026 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний нэр, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн
	Эхлэх	Дуусах		
Цагдаагийн газрын барилга, /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2024	2026	4,485,0	1,034,7
Хилийн цэргийн 0243 дугаар ангийн авто граж, авто засварын барилга /Сэлэнгэ, Сүхбаатар/	2026	2027	3,017,2	1,357,8
Цэвэрлэх байгууламжийн барилга /Сэлэнгэ, Баянгол сум/	2024	2026	4,572,9	1,597,4
Сургуулийн барилга, 640 суудал /Сэлэнгэ, Мандал, 2-р сургууль /	2024	2027	11,336,1	3,694,0
Сургуулийн спорт заалны барилга /Сэлэнгэ, Сайхан сум, Номгон тосгон/	2024	2026	1,415,2	424,1
Сургуулийн спорт заалны барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум, 1-р сургууль/	2026	2027	2,784,0	1,252,8
Соёлын төвийн барилга 400 суудал /Сэлэнгэ, Ерөө сум/	2024	2026	3,847,6	360,2
Соёлын салбарын тоног төхөөрөмж /Сэлэнгэ, Дархан-Уул, Төв/	2024	2026	1,407,4	275,0
Спорт заалны барилга /Сэлэнгэ, Жавхлант сум/	2024	2027	2,455,5	583,8
Спорт заалны барилга /Сэлэнгэ, Орхон сум, 1 дүгээр баг/	2024	2026	2,554,2	687,0
Спорт цогцолборын барилга /Сэлэнгэ, Сайхан сум/	2026	2028	6,728,8	2,018,7
Баруунбүрэн-Амарбаягалан хийд чиглэлийн хатуу хучилттай авто зам 33,4 км /Төвийн бүс/	2025	2027	39,472,1	15,000,0
Мандал сумын Түнхэл тосгоноос Төв аймгийн Батсүмбэр хүртэлх хатуу хучилттай авто зам /Төвийн бүс/	2025	2027	52,414,8	12,348,9
Орхонтуул-Цээл чиглэлийн хатуу хучилттай авто зам 62,56 км /Төвийн бүс/	2025	2028	117,450,0	25,000,0
Хушаат сумыг улсын чанартай авто замд холбох хатуу хучилттай авто замын дуусгал /Төвийн бүс/	2025	2026	13,880,4	6,940,2
Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам 6,3 км /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2024	2026	9,444,4	3,959,9
Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 10,3 км /Сэлэнгэ, Мандал сум/	2024	2026	10,004,7	4,031,3
Төмс, хүнсний ногооны зоорь, 200 тн, 500 тн, /Сэлэнгэ, Орхон, Мандал, Баянгол,Шаамар, Хушаат, Жавхлант, Зүүнбүрэн сум/	2024	2026	13,548,0	6,416,2
Аж үйлдвэрийн агропарк /Сэлэнгэ/	2024	2026	5,000,0	2,939,9

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс
Орон нутгийн хөгжлийн санд олгох орлого 24,972,6 сая төгрөг.

ТӨВ АЙМАГТ 2026 ОНД УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ

2026 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний нэр, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн
	Эхлэх	Дуусах		
Цагдаагийн газрын барилга, /Төв, Зуунмод сум/	2024	2026	4,681,7	686,1
Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станцын 2 дугаар хэлхээ, дэд бүтэц /Төв/	2025	2026	3,513,7	1,935,5
Шинэ зуунмод хотын 110 кв-ын 2 хэлхээт ЦДАШ, 110/35/10 кв"АЭРОСИТИ" дэд станцын барилга угсратын ажлын үргэлжлэл /Төв, Сэргэлэн сум/	2025	2027	24,984,5	8,073,4
"Хөшигтийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэж" төсөл /Төв/	2023	2026	135,583,3	37,090,7
Дулааны станцын халаалтын 1,2,3,4,5,6,7 дугаар хэсгийн 2-р хэлхээний шугам сүлжээний өргөтгөл шинэчлэл /Төв, Зуунмод сум/	2022	2027	27,578,5	5,000,0
Гэр хорооллын инженерийн хангамжийн шугам шүлжээ /Төв, Зуунмод сум 6-р баг/	2024	2026	16,671,1	5,992,2
Орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээ /Төв, Зуунмод сум/	2022	2026	6,036,5	4,499,3
Дотуур байрны барилга, /Төв, Баянчандмань сум/	2024	2026	3,500,0	1,069,0
Сургуулийн барилга 320 суудал /Төв, Борнуур сум/	2024	2026	5,483,9	2,481,0
Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Төв, Зуунмод, 5-р сургууль/	2024	2026	7,162,6	3,327,7
Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал /Төв, Зуунмод, Хүмүүн цогцолбор сургуулийн А байр/	2024	2026	13,040,2	4,146,2
Цэцэрлэгийн барилга 150 ор /Төв, Баянцогт сум/	2024	2026	2,800,0	1,573,9
Сургуулийн барилга, 320 суудал /Төв, Заамар сум, Хайлааст баг/	2021	2026	6,200,0	576,4
Сургуулийн барилгын өргөтгөл 320 суудал /Төв, Заамар сум/	2020	2026	2,296,8	335,1
Сургуулийн барилга, 920 суудал /Төв Батсүмбэр сум/	2019	2026	9,920,2	100,1
Дотуур байрны барилга, 150 ор /Төв, Зуунмод сум/	2026	2027	4,601,0	2,070,5
Соёл, спортын төвийн барилга250 суудал /Төв, Баянжаргалан сум/	2020	2026	3,648,6	504,0
Батсүмбэр сумаас Ахмад настны үндэсний төв хүртэлх хатуу хучилттай авто зам 10,7 км /Төв, Батсүмбэр сум/	2024	2026	13,279,1	4,668,6
Үерийн далан 3,8 км /Төв, Лүн сум/	2024	2026	4,754,5	2,200,0
Төв аймгийн Угтаалцайдам, Цээл, Заамар сумдыг холбох хатуу хучилттай авто зам, 122,4 км /Төв,Угтаалцайдам,Цээл, Заамар сум/	2022	2026	182,566,3	80,101,1
Багануур-Мөнгөнморьт чиглэлийн хатуу хучилттай авто зам 60 км /Төв, Мөнгөн морьт сум/	2019	2026	52,102,0	4,000,1
"Халдварт өвчин судлалын үндэсний төв 2"-ийн гадна инженерийн шугам сүлжээ /Төв, Сэргэлэн сум/	2024	2026	12,672,3	6,317,8

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс
Орон нутгийн хөгжлийн санд олгох орлого 22,891,4 сая төгрөг.

ДАРХАН-УУЛ АЙМАГТ 2026 ОНД

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ

2026 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний нэр, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн
	Эхлэх	Дуусах		
Хорооллын дулаан хангамж/Дархан-Уул, Дархан сум, 31-р хороолол/	2024	2026	10,475,3	3,920,0
Барилгын материалын сорилт, шинжилгээний лабораторийн барилга Дархан-Уул, Дархан сум/	2024	2026	3,325,1	691,0
Залуус 1,2-р хорооллын инженерийн шугам сүлжээ, цахилгаан хамгамж /Дархан-Уул, Дархан сум/	2024	2026	29,150,9	10,983,9
Үерийн байгууламж /Дархан-Уул, Дархан сум/	2024	2026	3,355,7	775,6
Хабитат, мангирт чиглэлийн дулаан хангамжийн 2-р контур /Дархан-Уул, Дархан сум, 15-р баг/	2022	2026	8,339,3	739,3
Үерийн хамгаалалтын барилга байгууламж, далан суваг /Дархан-Уул, Шарын гол сум/	2026	2028	3,556,5	1,067,0
Анагаахын ШУ-ны үндэсний их сургуулийн Дархан-Уул аймаг дахь салбар,анагаах ухааны сургуулийн эмнэлгийн өргөтгөлийн барилга /Дархан-Уул, Дархан сум/	2024	2027	16,268,2	5,180,8
Сургуулийн барилга 1500 суудал /Дархан-Уул, Дархан сум/	2024	2027	24,976,5	5,647,6
Сургуулийн барилга 480 суудал /Дархан-Уул Орхон сум/	2024	2026	10,695,1	4,937,5
Сургуулийн барилгын өргөтгөл, 960 суудал /Дархан-Уул аймаг, Дархан сум, 10-р баг Оюуны ирээдүй цогцолбор сургууль/	2024	2027	19,635,0	6,381,4
Цэцэрлэгийн барилга, 100 ор /Дархан-Уул, Дархан сум, 2-р баг/	2024	2026	3,301,9	423,1
Цэцэрлэгийн барилга 100 ор /Дархан-Уул, Дархан сум, Малчин баг/	2024	2026	3,831,5	2,394,0
Цэцэрлэгийн барилга 150 ор /Дархан-Уул, Дархан сум, 14 дүгээр баг/	2024	2026	5,438,8	2,778,8
Өвлийн спортын ордны барилга /Дархан-Уул, Дархан сум/	2024	2027	22,438,0	6,423,7
Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам 6,3 км /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2024	2026	9,444,4	3,959,9
Гэр хорооллын доторх хатуу хучилттай авто зам /Дархан-Уул, Дархан сум/	2024	2026	8,000,0	3,040,5
Сумын төвийн 8-р багийг 1-р багтай холбох авто замын гүүрэн гарц /Дархан-Уул, Дархан сум/	2018	2022026	8,048,4	1,094,5
Төвийн бүсийн хөнгөн хүнсний үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц /Дархан-Уул, Хонгор сум/	2024	2027	23,814,7	8,335,1
Өрхийн эмнэлгийн барилгын өргөтгөл /Дархан-Уул, Дархан сум, Амин холбоо өрхийн эмнэлэг/	2024	2026	1,442,3	279,1
Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга /дархан-Уул, Дархан сум/	2024	2026	1,834,8	359,0
Дархан-Уул аймгийн шүүхийн барилга	2025	2026	12,213,5	7,285,5

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлого 12,586,4 сая төгрөг.

IV

ЯАМНЫ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОХ ҮР ДҮН

Соёл, спорт, аялал жуулчлалын яамнаас соёл, урлагийн салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хуулиудын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж байна. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-д тусгагдсан “зорилгод хүрэх түвшин” болон “практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу Соёлын тухай хуулийн хэрэгжилт, үр дагаварт үнэлгээ дүгнэлт өгч, Номын сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулан, үзэл баримтлалыг боловсруулаад байна.

Энэ хүрээнд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл, тулгамдаж байгаа асуудал болон хэрэгцээ шаардлагыг нарийвчлан тодорхойлох ажлуудыг үе шаттайгаар хийж гүйцэтгэлээ.

Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгосноор Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд соёлын талаар тусгасан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх үндсэн нөхцөл бүрдэнэ. Энэхүү шинэчлэлийн хүрээнд соёл, урлагаар дамжуулан хүний хөгжлийг дэмжих, бүтээх, туурвих, түгээх цогц үйл ажиллагаанд гадаад, дотоод дахь нийт иргэдийнхээ оролцоог хангах замаар соёлын зөөлөн хүчний бодлогыг хэрэгжүүлэх стратегийг баримтлах бөгөөд соёл, урлагийн байгууллагын удирдлага, менежмент, үйл ажиллагааны зохион байгуулалтыг олон улсын түвшинд хүргэх ач холбогдолтой юм.

IV.1 СОЁЛ, УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР

НОМЫН САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ БОЛОВСРУУЛЛАА

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас “Номын сангийн тухай хуулийг шинэчлэх хэрэгцээ, шаардлага, тулгамдаж буй асуудал” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Энэхүү хэлэлцүүлэгт Монгол Улсын Үндэсний номын сангийн ерөнхий номын санч Т.Баярлах, МУИС-ийн номын сангийн захирал Г.Цэрэн, Хотын төв номын сангийн захирал Д.Индра, Хүүхдийн төв номын сангийн Мэдээлэл технологи, арга зүйн хэлтсийн дарга Д.Тунгалаг, ЕБС-ийн номын сангуудын холбооны тэргүүн Н.Отгонжаргал зэрэг нийтийн болон их, дээд сургууль, ерөнхий боловсролын сургуулийн номын сангуудын 20 гаруй төлөөлөл оролцож, салбарын тулгамдсан асуудлаар илтгэл хэлэлцүүлэв.

Номын сангийн үйлчилгээний чанар, хүртээмжийг олон улсын жишигт нийцүүлэн нэмэгдүүлж, иргэн бүрийн тасралтгүй сурч боловсрох, өөрийгөө хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлэн, хүний хөгжлийг дэмжих зорилгоор “Номын сангийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахаар Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2026 оны А/75 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Ажлын хэсэгт Монгол Улсын Үндэсний номын сан (МҮҮНС), Монгол Улсын Их Сургуулийн (МУИС) номын сан, Хүүхдийн төв номын сан, Нобелийн шагналтнуудын нэрэмжит хүүхдийн номын сан зэрэг мэргэжлийн байгууллагуудын төлөөлөл ажиллаж байгаа бөгөөд хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалыг эцэслэн боловсруулаад байна.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ, МОРИН ХУУРАА ЭРХЭМЛЭН ДЭЭДЭЛЖ, ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЛЭЭ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 09 дүгээр зарлиг, ЗГ-ын 2024 оны 59 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх талаар авах арга хэмжээний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын ордонд морин хуурын эрдэм шинжилгээний анхдугаар хурлыг зохион байгууллаа. Хурлаар үеэр морин хуур хөгжмийн зэмсгийн үзэсгэлэн гарган, морин хуурын үүсэл хөгжил болон хийц, сургалт, урын сан, тоглох арга барил, уран бүтээлчдийн ур чадвар, морин хуурын хөгжилд оруулсан хувь нэмэр болон ахмад залуу уран бүтээлчдийн талаар илтгэлийг хэлэлцүүлж, цаашид морин хуурыг хөгжүүлэх бодлогыг тодорхойлов.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН НЭРЭМЖИТ ШАГНАЛЫГ ДЭЛХИЙН ШИЛДЭГ БАРИТОН Э.АМАРТҮВШИНД ОЛГОВ

Монгол үндэстний үнэт зүйл, бахархлыг дэлхий дахинд түгээн дэлгэрүүлж, Монгол хүний яруу төгөлдөр авьяас, чин зүтгэл, хосгүй ур чадвараар дэлхийн дуурийн урлагийг түүчээлж буй үйлсийг нь өндрөөр үнэллээ. Сонгодог урлагийн хөгжилд жинтэй хувь нэмэр оруулж, эх орноо олон улсад сурталчлан таниулж буй амжилтыг нь мялааж, Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит шагналыг дэлхийн шилдэг дуурийн дуучин, Ардын жүжигчин Энхбатын Амартүвшинд олгов.

СОЁЛ, УРЛАГИЙН НЭРТ ЗҮТГЭЛТНҮҮДИЙН ТҮҮХЭН ОЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ ШИЙДВЭР ГАРЛАА

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 60 дугаар тогтоолоор Монголын соёл, урлагийн сор болсон нэрт зүтгэлтнүүдийн түүхэн ойг 2026 онд орон даяар тэмдэглэн өнгөрүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

- Хөдөлмөрийн баатар, хөгжмийн зохиолч Дагвын Лувсаншаравын мэндэлсний 100 жил;
- Төрийн шагналт, хөгжмийн зохиолч Эрэгзэний Чойдогийн мэндэлсний 100 жил;
- Соёлын гавьяат зүтгэлтэн, урлаг судлаач Жамцын Бадраагийн мэндэлсний 100 жил;
- Ардын жүжигчин, Төрийн шагналт хөгжмийн зохиолч Гончигийн Бирваагийн мэндэлсний 110 жил;
- Төрийн шагналт, нэрт бүжиг дэглээч Цэрэндуламын Сэвжидийн мэндэлсний 110 жилийн ой тус тус тохиож байна.



СОЁЛ, УРЛАГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН БҮТЭЦ, ДҮРМИЙГ ШИНЭЧЛЭН БАТАЛЖ, ХӨГЖМИЙН ЗЭМСГИЙН ШИНЭЧЛЭЛ ХИЙЛЭЭ

Соёл, урлагийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор мандатын шинжилгээ хийсний үндсэн дээр Дуурь, бүжгийн эрдмийн театр, Улсын филармони, Хүүхэлдэйн театрын бүтэц, дүрмийг шинэчлэн баталлаа.

Мөн Дуурь, бүжгийн эрдмийн театрын симфони найрал хөгжмийн зэмсгийн шинэчлэлийг эхлүүлэв. Сүүлийн 10-20 жил шинэчлэгдээгүй байсан үлээвэр болон цохивор хөгжмийн зэмсгүүдийг 2026 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар иж бүрэн шинэчилж, мэргэжлийн уран бүтээлчдийн ажиллах орчин, бүтээлийн чанарт ахиц гаргалаа.

ТӨВ АЗИЙН СОЁЛЫН ЯАМДЫН ХАМТАРСАН “АЗИЙН СТОРИТЕЛЛИНГ ХОРООНЫ ОЛОН УЛСЫН ХУРАЛ”-ЫГ МОНГОЛ УЛСАД ЗОХИОН БАЙГУУЛЛАА

2025.08.22-24

Азийн сторителлингийн хорооны 17 дахь удаагийн хурлыг Монгол Улсад зохион байгуулж, БНСУ, БНКирУ, БНУзУ, БНКазУ-ын Соёлын яамдын төлөөлөл оролцлоо. Хурлаар гишүүн орнуудын домог, түүх, баатарлаг туульсын сэдэвт хүүхдийн номыг хэвлэн гаргаж, жүжиг, хөгжимт жүжиг болон дижитал контент хэлбэрээр дэлхий дахинд сурталчлан таниулах хамтын ажиллагааны талаар хэлэлцэв. Энэ үеэр БНСУ-ын Үндэсний Ази соёлын төв (ACC)-ийн санхүүжилтээр Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, хүүхдийн зохиолч О.Сундуй, БНСУ-ын зураач Ли Ерин нарын хамтран бүтээсэн “Хадны зургийн ертөнцөөр аялсан нь” зурагт ном солонгос хэлээр хэвлэгдэн, хоёр улсад зэрэг нээлтээ хийлээ. Уг номын агуулгад тулгуурлан “Чингис хаан” Үндэсний музейд дижитал интерактив проекц байрлуулан соёлын боловсролын хөтөлбөр хэрэгжүүлж, 1000 гаруй хүүхдийг хамруулсан байна.

САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ЦИРКИЙН СУРАГЧДЫГ ОХУ-Д СУРАЛЦАХАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЛЭЭ 2025.09.10

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрам Монгол циркийн уран бүтээлчдийн залуу үеийн төлөөлөл болох Оросын Холбооны Улсын Москва хотын “Цирк, эстрадын дунд сургууль” (Государственное училище циркового и эстрадного искусства им. М.Н.Румянцева)-д суралцахаар шалгарсан 13 залуу уран бүтээлчийг хүлээн авч уулзлаа. Эдгээр сурагчид 2025-2029 онд ОХУ-ын Засгийн газрын тэтгэлгээр суралцах бөгөөд тус сургуулийг манай улсаас хамгийн сүүлд 1987 онд зургаан оюутан төгсөж байсан түүхтэй.

ҮНДЭСНИЙ ХЭЛ, БИЧИГ СОЁЛЫН ӨДРҮҮДИЙГ ОРОН ДАЯАР ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЛЭЭ 2025.09.19-21

“Үндэсний бичиг үсгийн баяр-2025” арга хэмжээг улс орон даяар нэгдмэл өнгө төрх, агуулгатайгаар тэмдэглэн өнгөрүүллээ. Улсын хэмжээнд нийслэл, 21 аймаг, боловсрол, төр, хувийн хэвшлийн байгууллагууд хамтран 200 гаруй арга хэмжээг зохион байгуулж, 60 гаруй мянган хүүхэд залуучууд, иргэдийг хамруулав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагддаг “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд”-ийн хавар, намрын арга хэмжээнд 150 орчим номын худалдаа эрхлэгч, 400 орчим хэвлэн нийтлэгч, зохиолч яруу найрагч, 290 орчим аж ахуйн нэгж байгууллага оролцож, давхардсан тоогоор 1500 гаруй арга хэмжээнд нийт 670 мянга гаруй иргэн хамрагдсан нь нийгэмд эерэг хандлага, уншлагын соёлыг төлөвшүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж байна.

НОМОНД ДУРЛАГСДЫН ХҮСЭН ХҮЛЭЭДЭГ “УТГА ЗОХИОЛЫН ДОЛОО ХОНОГ” АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА 2025.09.22-28

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл болох утга зохиол, ном хэвлэлийн салбарыг хөгжүүлэх, нийгэмд гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, хүүхэд залууст эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор “Утга зохиолын долоо хоног” аяныг өргөн цар хүрээтэй өрнүүллээ. Тус аяны хүрээнд УДЭТ-аас санаачилсан жүжгийн зохиолын улсын уралдаанд 150 гаруй бүтээл ирсэн нь тайзны урлагийн өв санг баяжуулах, шинэ уран бүтээлчийг нээн илрүүлэхэд чухал түлхэц болов. Мөн “Шинэ үеийн уншигч” хэлэлцүүлэг, “Өдрийн шүлэг”, “Номын баярын дурсамж” уралдаан, номын үзэсгэлэн худалдаа, дүүрэг бүрд ардын урлагийн тоглолт, уран уншлага зэрэг 600 гаруй арга хэмжээг зохион байгуулж, 90 мянга орчим иргэнд хүрч үйлчиллээ.

КИНО УРАН БҮТЭЭЛЧИД “МОНГОЛ УЛСАД КИНО УРЛАГ ҮҮСЭЖ ХӨГЖСӨНИЙ 90 ЖИЛИЙН ОЙ”-ГОО ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЛЭЭ 2025.10.29

Монгол Улсад кино урлаг үүсэж хөгжсөний 90 жилийн ойг тохиолдуулан, үндэсний кино урлагийн хөгжил, кино уран бүтээлчдийн үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 103 дугаар тогтоолоор жил бүрийн 10 дугаар сарын 11-ний өдрийг “Үндэсний кино урлагийн өдөр” болгон тэмдэглэж байхаар шийдвэрлэлээ. Ойн баярын хүндэтгэлийн тоглолт, арга хэмжээг Төрийн ордонд ёслол төгөлдөр зохион байгуулав.

ХӨГЖИМ, ДҮРСЛЭХ УРЛАГ БОЛОН УТГА ЗОХИОЛЫН ШИЛДЭГ БҮТЭЭЛЭЭР УЛСЫН САНГ БАЯЖУУЛАХ ЭРХ ЗҮЙН ТААТАЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЛЭЭ

2025.11.22

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 159 дүгээр тогтоолоор “Хөгжим, дүрслэх урлаг, утга зохиолын шилдэг бүтээлийг улсын санд худалдан авах, хадгалах, ашиглах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулан батлууллаа. Энэхүү өөрчлөлт нь хөгжим, дүрслэх урлаг, утга зохиолын бүтээлийн чанар чансааг сайжруулах, уран бүтээлчдэд ил тод, нээлттэй, тэгш боломж олгох, уран бүтээлийн зах зээлийн үнэлгээг нэмэгдүүлэх, улмаар нийгмийн хөгжилд үр нөлөөтэй ашиглах нөхцөлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 11 сарын 12 өдөр Дугаар 159 Улаанбаатар хот

ЖУРАМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Соёлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Журам батлах тухай" Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 391 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Хөгжмийн зохиолын шилдэг бүтээл шалгаруулах, улсын санд худалдан авах, хадгалах, ашиглах журам"-ын 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 1.4 дэх хэсэг нэмсүгэй:

"1.4.Шаардлагатай тохиолдолд тусгайлан сонгон шалгаруулалт зарлахдаа энэ журмын 1.3-т заасан уран бүтээлийн төрлөөс тухайлан

С.ГОНЧИГСУМЛААГИЙН НЭРЭМЖИТ МЭРГЭЖЛИЙН ХӨГЖИМЧДИЙН УЛСЫН УРАЛДААН БОЛЛОО 2025.11.20-25

Монгол Улсын Ардын жүжигчин, Төрийн шагналт нэрт хөгжмийн зохиолч Сэмбийн Гончигсумлаагийн нэрэмжит “Төгөлдөр хуур, чавхдаст хөгжимчдийн улсын V уралдаан”-ыг 12 жилийн дараа УБДЭТ-т амжилттай зохион байгууллаа. ССАЖЗЯ-ны бодлого, санхүүгийн дэмжлэгтэйгээр Монголын Урлагийн ажилтны холбооноос зохион байгуулсан тус уралдаанд мэргэжлийн урлагийн байгууллагын уран бүтээлчид, оюутан сурагчид оролцож, шилдгүүдийн нэгдсэн тоглолтыг 300 гаруй үзэгчдэд толилуулав.

МОНГОЛ УЛСЫН ТӨР, НИЙГМИЙН НЭРТ ЗҮТГЭЛТЭН БЯМБЫН РИНЧЕНИЙГ АЛДАРШУУЛЖ, ХОЙЧ ҮЕДЭЭ ТАНИУЛАН СУРТАЛЧИЛЛАА

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 67 дугаар тогтоолоор Монгол Улсын Төрийн шагналт, академич Б.Ринчений мэндэлсний 120 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүллээ. Б.Ринчен нь хэл шинжлэл, уран зохиол, орчуулга, угсаатны зүй зэрэг олон салбарт үнэлж баршгүй бүтээл туурвисан, монгол хэл, соёлын үнэт өвийг хамгаалан хөгжүүлэхэд онцгой гавьяа байгуулсан нэрт эрдэмтэн юм. Ойн хүрээнд ССАЖЗ-ын сайдын тушаалаар байгуулагдсан салбар дундын ажлын хэсэг “Б.Ринчен судлал-120” олон улсын эрдэм шинжилгээний хурал, архивын ховор баримт, ном зохиолын үзэсгэлэн, “Б.Ринчен Цогт тайж киногоор юу хэлэв?” телевизийн нэвтрүүлэг бэлтгэх зэргээр соён гэгээрлийн үйл хэргийг олон нийтэд сурталчлах ажлыг амжилттай зохион байгууллаа.

“МОНГОЛ УРЛАГ-ДЭЛХИЙН ТАЙЗНАА” ҮНДЭСНИЙ СУРТАЛЧИЛГААГ 2.6 САЯ ҮЗЭГЧДЭД ХҮРГЭЛЭЭ

Үндэсний соёл, урлагийг олон улсад сурталчлан таниулах бодлогын хүрээнд нийт 16 улсад 27 удаагийн биe даасан тоглолт, арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Эдгээр арга хэмжээг давхардсан тоогоор 2.6 сая үзэгч үзэж сонирхсон байна. Түүнчлэн төрийн өндөр түвшний 7 удаагийн албан айлчлалын хүрээнд соёл, урлагийн 21 тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлж, Монгол Улсын “зөөлөн хүчний” бодлогыг олон улсын тавцанд бататгалаа.

СОЁЛЫН ХҮРТЭЭМЖ БА СОЁЛЫН ОРОН ЗАЙ БҮТЭЭЛЧ АЯ ӨРНҮҮЛЛЭЭ

Иргэдийн соёл, урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 2025 онд хүртээмжийн үзүүлэлт 53.4 хувьд хүрч, төлөвлөсөн зорилтот түвшнээс (50%) давсан үзүүлэлттэй гарлаа.

- Бүтээлч аян: "Соёлын орон зай – бидний орчин" аяныг үндэсний хэмжээнд өрнүүлж, эх хэл, бичиг соёл, уран зохиолын үнэ цэнийг сурталчлах ажлаар дамжуулан 760,800 иргэнийг соён гэгээрүүлэх арга хэмжээнд хамруулав.
- Орон нутгийн сүлжээ: Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 347 соёлын төв, ордны 96 хувь нь буюу 333 нь орон нутагт иргэдэд үйлчилж байна.



"СОЁЛ УРЛАГ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ-2026" ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА 2026.01.08-09

Төв аймагт болсон тус зөвлөлдөх уулзалтад яам, орон нутгийн захиргааны байгууллагууд, төрийн өмчийн соёл, урлагийн байгууллагын удирдлага, мэргэжлийн холбоодын 300 орчим төлөөлөл оролцож, үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлт, 2026 оны томоохон арга хэмжээнүүдийн уялдаа холбоог хэлэлцэж баталлаа.

IV.2 СОЁЛЫН ӨВИЙН ЧИГЛЭЛЭЭР

ӨНДӨР ГЭГЭЭН ЗАНАБАЗАРЫН ӨВИЙГ АЛДАРШУУЛАН СУРТАЛЧЛАВ 2025 оны 7-11 сар

Монголын төр, нийгэм, шашны нэрт зүтгэлтэн Өндөр гэгээн Занабазарын мэндэлсний 390 жилийн ойн хүрээнд Дүрслэх урлагийн музейд “Өндөр гэгээний өв дүрслэх урлагт”, Чингис хаан үндэсний музейд “Чингис хааны удмын хутагт: Дорнын их сэргэн мандалт” тусгай үзэсгэлэнгүүдийг зохион байгууллаа. Эдгээр үзэсгэлэнд Өндөр гэгээний мутрын болон дэг сургуулийн ховор нандин бүтээлүүдийг анх удаа нэг дор дэглэн үзүүлсэн нь үзэгчдийн сонирхлыг ихэд татлаа.

“НҮҮДЭЛЧИН” ДЭЛХИЙН СОЁЛЫН ФЕСТИВАЛИЙГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАВ 2025.08.22-24

“Нүүдэлчин 2025” дэлхийн соёлын фестивалийг Улаанбаатар хотын Налайх дүүргийн Тайж хайрхан уулын бэлд гурван өдрийн турш амжилттай зохион байгууллаа. Фестивалийг давхардсан тоогоор 260 мянга гаруй дотоод, гадаадын үзэгч үзэж сонирхсон нь өмнөх онтой харьцуулахад үзэгчдийн тоо 53 хувиар өссөн үзүүлэлт юм.

Арга хэмжээний үеэр соёлын биет бус өвийн 7 ай савын хүрээнд 250 өвийн 800 орчим хөтөлбөрийг 852 өвлөн уламжлагч, 239 өвлөн суралцагч олон нийтэд таниулан сурталчиллаа. Мөн соёлын өв, жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 260 орчим байгууллага оролцож, 1.8 тэрбум төгрөгийн эдийн засгийн эргэлтийг бий болгов. Энэхүү фестивалийг ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенц болон Монгол Улсын Засгийн газрын холбогдох тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд уламжлал болгон зохион байгуулж байна.

МОНГОЛ УЛС ДЭЛХИЙН ӨВИЙН ХОРООНЫ ГИШҮҮНЭЭР АНХ УДАА СОНГОГДЛОО 2025.11.24-25

БНФУ-ын Парис хотноо зохион байгуулагдсан ЮНЕСКО-гийн 43 дугаар Бага хурлын хаалтын үеэр Дэлхийн байгалийн болон соёлын өвийг хамгаалах тухай 1972 оны конвенцын 25 дугаар Ерөнхий Ассамблей хуралдаж, Дэлхийн өвийн хорооны гишүүний сонгууль явагдлаа. Тус сонгуульд таван суудлын төлөө 15 улс өрсөлдсөнөөс Монгол Улс нийт 97 улсын саналаар Дэлхийн өвийн хорооны гишүүнээр 2025-2029 онд ажиллахаар түүхэндээ анх удаагаа сонгогдов. Энэхүү амжилт нь Монгол Улсаас олон улсын тавцанд явуулж буй соёлын гадаад бодлого, хамтын ажиллагааны чухал үр дүн боллоо.





МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРЭЭС ХУЛГАЙЛАГДСАН ҮЛЭГ ГҮРВЭЛИЙН ЧУЛУУЖСАН ОЛДВОРЫГ ЭРГҮҮЛЭН АВЛАА 2025.12.08.

Бүгд Найрамдах Франц Улсын хууль сахиулах байгууллагаас 2013, 2015 онд хураан авсан үлэг гүрвэлийн чулуужсан олдворыг Монгол Улсад үнэ төлбөргүйгээр буцаан олгох актад гарын үсэг зурах ёслол Парис хотноо боллоо. Арга хэмжээнд Монгол Улсын Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрам, БНФУ-ын Төрийн сан, үйл ажиллагааны сайд Амели де Мончалин нар оролцож, гарын үсэг зуран хүлээлцлээ. Шинжээчдийн дүгнэлтээр эдгээр 29 багц олдвор нь 70-65 сая жилийн тэртээ Монголын говьд амьдарч байсан тарбозавр батаар, теропод, орнитомимозавр зэрэг шинжлэх ухааны нэн өндөр ач холбогдолтой олдворууд болох нь батлагдсан юм.

ТӨРИЙН ӨМЧИЙН МУЗЕЙНҮҮДЭД ЗЭРЭГЛЭЛ ТОГТООЛОО 2025.12.24

Засгийн газрын 2025 оны 220 дугаар тогтоолоор дараах музейнүүдийн зэрэглэлийг шинэчлэн тогтоов:

- “Улсын” зэрэглэл: Монголын уран зургийн галерей, Богд хааны ордон музей, Дүрслэх урлагийн музей, Монгол цэргийн музей, Монголын театрын музей, Хөшөө цайдам музей, Чойжин ламын сүм музей.
- “Бүс нутгийн” зэрэглэл: Хархорум музей.

Музейд зэрэглэл тогтоосноор сан хөмрөгийг хадгалах, хамгаалах, сурталчлах нэгдсэн стандарт нэвтрэх бөгөөд соёлын аялал жуулчлал, бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд эерэг нөлөө үзүүлэх юм.

БАЙГАЛИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ МУЗЕЙ БАЙГУУЛАГДЛАА 2025.12.31

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 244 дүгээр тогтоолоор байгалийн шинжлэх ухааны олон талт судлалыг хөгжүүлэх, эрдэм шинжилгээний ажлыг өргөжүүлэх, үзмэр, цуглуулгыг эргэлтэд оруулах зорилгоор "Байгалийн түүхийн музей"-г "Байгалийн шинжлэх ухааны үндэсний музей" болгон өөрчлөн байгуулав.

Тус музей нь 2026 оноос Хан-Уул дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт баригдаж буй 41,000 м.кв талбайтай, орчин үеийн шийдэл бүхий шинэ байранд үйл ажиллагаагаа явуулна. Энэхүү бүтээн байгуулалт нь байгаль орчныг хамгаалах үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, бүс нутгийн хэмжээнд өрсөлдөх чадвартай томоохон музейн цогцолбор болж хөгжих юм.

ИТАЛИ УЛСАД ӨНДӨР ГЭГЭЭН ЗАНАБАЗАРЫН БҮТЭЭЛЭЭР ТУСГАЙ ҮЗЭСГЭЛЭН ГАРГАВ 2026.01.20-02.22

Италийн Ром хотын алдарт “Borghese” галерейд “Монголоос Барокко ертөнц рүү” үзэсгэлэн амжилттай нээгдлээ. Үзэсгэлэнд Чингис хаан үндэсний музейн сан хөмрөгт хадгалагдаж буй Монгол Улсын түүх, соёлын хосгүй үнэт дурсгал болох Өндөр гэгээний мутрын бүтээл “Ногоон Дара эх”, “Занабазар” зөрөг хөрөг зэрэг бүтээлүүд тавигдаж байна. Одоо тус үзэсгэлэн Италийн Турин хотын Дорно дахины урлагийн музейд “Занабазар: Тал нутгийн мэлмий” нэртэйгээр үргэлжлэн гарч, дэлхийн үзэгчдэд Монголын соёлын гайхамшгийг сурталчилж байна.

УСАН ДООРХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ КОНВЕНЦОД НЭГДЭН ОРОХООР ШИЙДВЭРЛЭЛЭЭ 2026.02.25

Засгийн газрын ээлжит хуралдаанаар ЮНЕСКО-ийн “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтов.

Монгол Улс далайд гарцгүй боловч байгаль эхээ шүтэх үзэл санааны хүрээнд нуур, гол мөрөнд үнэт зүйлс өргөх зан үйл болон Хөвсгөл нууранд хадгалагдан үлдсэн эртний усан онгоц зэрэг түүх, археологийн чухал олдворууд байдаг. Энэхүү конвенцод нэгдсэнээр усан доорх соёлын биет өвийг олон улсын хэм хэмжээний дагуу хамгаалж, бүрэн бүтэн байдлаар нь хойч үедээ өвлүүлэн үлдээх боломж бүрдэх юм.

IV.3 СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР

ДЭЛХИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ 3Х3 САГСАН БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭНД МОНГОЛЫН ЭМЭГТЭЙ БАГ ТАМИРЧИД ЯЛАЛТ БАЙГУУЛЛАА 2025.06.23-29

Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан Дэлхийн аварга шалгаруулах 3х3 сагсан бөмбөгийн тэмцээнд Монгол Улсын эмэгтэй сагсан бөмбөгийн 3х3 үндэсний шигшээ баг тамирчид мөнгөн медаль хүртлээ. Энэхүү түүхэн амжилт нь Монгол Улсын хүүхэд, залуучуудад үлгэр дуурайл болж, монгол хүнээрээ бахархах омогшлыг төрүүлэн, эх орноо дэлхий дахинд сурталчлах үйлсэд онцгой хувь нэмэр оруулсан юм. Засгийн газрын 2025 оны 92 дугаар тогтоолоор тус баг тамирчдад Ерөнхий сайдын нэрэмжит мөнгөн шагнал болох 500 сая төгрөгийг олгож алдаршууллаа.

“ХҮН АМЫН БИЕ БЯЛДРЫН ҮЗҮҮЛЭЛТ, ТҮВШИН ТОГТООХ, ҮР ДҮНГ ТООЦОХ ЖУРАМ”-ИЙГ БАТЛУУЛСНААР ИРГЭН БҮРИЙН ИДЭВХТЭЙ АМЬДРАЛЫГ ҮНЭЛДЭГ БОЛЛОО 2025.09.17

Биеийн тамир, спортын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.6 дахь заалтыг үндэслэн “Хүн амын бие бялдрын үзүүлэлт, түвшин тогтоох, үр дүнг тооцох журам”-ыг боловсруулан Засгийн газрын 2025 оны 95 дугаар тогтоолоор батлууллаа. Энэхүү журам батлагдсанаар “Бие бялдрын түвшин тогтоох сорилын төв”-өөр дамжуулан иргэдэд идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, нас хүйс, биеийн онцлогт тулгуурласан эрүүл мэндийн мэдээллийн санг бүрдүүлэх, цаашид нотолгоонд суурилсан салбарын бодлого, стратеги боловсруулах эрх зүйн үндэс бүрдэж байгаагаараа онцлогтой.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 09 сарын 17 өдөр Дугаар 95 Улаанбаатар хот

ЖУРАМ, АРГАЧЛАЛ БАТЛАХ ТУХАЙ

Биеийн тамир, спортын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.6 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Хүн амын бие бялдрын сорилын үзүүлэлт, түвшин тогтоох, үр дүнг тооцох журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Хүн амын бие бялдрын сорилын түвшин тогтоох, үр дүнг тооцох аргачлал”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлуулсугай.

2.Энэ тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрамд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Г.ЗАНДАНШАТАР

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД Ч.УНДРАМ

МОНГОЛЫН БҮХ АРД ТҮМНИЙ СПОРТЫН ЗУНЫ XVI НААДАМ БОЛЛОО 2025.09.15-21

"Монголын бүх ард түмний спортын зуны XVI наадам"-ыг спортын 28 төрлөөр (олимпын 16, олимпын бус 2, оюун ухааны 2, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 8) Баянхонгор аймаг болон Улаанбаатар хотод нэгэн зэрэг амжилттай зохион байгууллаа. Наадмын шигшээ тэмцээнд 21 аймаг, 9 дүүргийн 3,400 гаруй баг тамирчид 879 багц медалийн төлөө өрсөлдсөнөөс нэгдсэн дүнгээр Баянзүрх дүүргийн баг 80 медаль (35 алт, 24 мөнгө, 21 хүрэл), Орхон аймаг 72 медаль (23 алт, 14 мөнгө, 35 хүрэл), хүчний байгууллагуудаас "Алдар" спорт хороо 125 медаль (57 алт, 33 мөнгө, 35 хүрэл) хүртэж тус тус тэргүүллээ. Амжилт үзүүлсэн 1,316 тамирчинд 1.3 тэрбум төгрөгийн мөнгөн шагналыг олгосон бөгөөд дараагийн XVII наадам 2029 онд зохион байгуулагдана.

“SPORTS IN 2025” ФОРУМ, ҮЗЭСГЭЛЭНГИЙН АРГА ХЭМЖЭЭГ АНХ УДАА ЗОХИОН БАЙГУУЛЛАА 2025.09.18-19

Биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор “SPORTS IN 2025” бизнесийн форум, үзэсгэлэнг ССАЖЗЯ болон “Спортын бизнесийн холбоо” хамтран анх удаа зохион байгууллаа. Форумд дотоодын хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчид, шийдвэр гаргагчид цуглаж, салбарын инновац, шинэ шийдлүүдийг танилцуулан хэлэлцүүлэг өрнүүлэв.

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН УЛСЫН ЗӨВЛӨГӨӨН БОЛЛОО 2025.10.09-12

ССАЖЗЯ, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороо хамтран “Биеийн тамир, спортын салбарын улсын зөвлөгөөн”-ийг Дархан-Уул аймагт зохион байгууллаа. Зөвлөгөөнд 21 аймаг, 9 дүүргийн спортын байгууллагын удирдлага, спортын холбоодын нийт 650 төлөөлөгч оролцож, салбарын урт хугацааны хөгжлийн төлөвлөлт, бодлогын шинэчлэл, хүний нөөцийг бэхжүүлэх асуудлаар 14 илтгэл хэлэлцүүлэн, цаашдын үйл ажиллагааны зөвлөмж гаргав.

ГАЛТ ЗЭВСГИЙН АШИГЛАЛТЫН ТАЛААР БАГЦ ЖУРМЫГ БАТАЛЖ, СПОРТЫН ЗОРИУЛАЛТТАЙ ГАЛТ ЗЭВСГИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОВ

2025.10.23

Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын хамтарсан тушаалаар “Спорт-сургалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий иргэн, хуулийн этгээдийн галт зэвсэг эзэмших, хадгалах журам”, “Буудлага үйлдэх байгууламж (тир)-д тавигдах шаардлага”, “Иргэний болон харуул хамгаалалтын ангилалд хамаарах галт зэвсэг, сумны нэр, төрлийн жагсаалт”-ыг тус тус батлуулан мөрдүүлж эхэллээ. Ингэснээр спортын буудлагын байгууламжийн аюулгүй ажиллагааны стандарт дээшилж, галт зэвсгийн бүртгэл, хяналт нэг мөр, ил тод болох нөхцөл бүрдэв.

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД, ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр | Дугаар А/383, А/112 | Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Галт зэвсгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1."Спорт-сургалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий иргэн, хуулийн этгээдийн галт зэвсэг эзэмших, хадгалах журам"-ыг хавсралтаар батлагдсугай.

2.Тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг спорт-сургалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдэд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын дарга /Бригадын генерал Т.Сүхболд/-д тус тус даалгасугай.

3.Энэ тушаалыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

4.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэнд, спортын сайд, Хууль зүйн сайдын 2015 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Журам батлах тухай" 468, А/268 дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД Ч.УНДРАМ

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Л.МӨНХБААТАР

“СПОРТООР ТОГТМОЛ ХИЧЭЭЛЛЭЭ” УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАВ 2025.12.16

Монгол Улсын УИХ-ын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо, Соёл, спорт, залуучуудын дэд хороо, ССАЖЗЯ хамтран “Спортоор тогтмол хичээллэе” сэдэвт хэлэлцүүлгийг Төрийн ордонд зохион байгууллаа. Хэлэлцүүлгээр салбарын хууль эрх зүйн орчин, санхүүжилт, тулгамдаж буй асуудал, татварын хөнгөлөлтөөр спортын дэд бүтцийг хөгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг асуудлаар салбарын 100 гаруй төлөөлөл оролцож, санал шийдлээ нэгтгэлээ.

ӨВЛИЙН 2026 ОНЫ ОЛИМПЫН НААДАМД ОРОЛЦОХ БАГ ТАМИРЧИДТАЙ УУЛЗЛАА 2026.01.07

Италийн Милан болон Кортина д'Ампеццо хотуудад зохион байгуулагдах Өвлийн олимпын наадамд эх орноо төлөөлөн оролцох эрхээ авсан уулын цанын тамирчдыг хүлээн авч уулзан, бэлтгэл сургуулилтад нь шаардлагатай дэмжлэг үзүүлэхээ илэрхийлж, амжилт хүслээ.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

MILANO CORTINA 2026

IV.4 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

ДОТООДЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ ОЛГОХ БОДЛОГЫГ БАТАЛЛАА 2025.08.15

Аялал жуулчлалын салбарын төлөөллүүдтэй хийсэн уулзалтын үр дүнд зөвхөн дотоодын аж ахуйн нэгжүүдэд зориулсан хөнгөлөлттэй зээлийн зохицуулалтыг хийлээ. Үүнд том оврын тээврийн нисэх онгоцны лизингийн урьдчилгаа төлбөр, D ангиллын болон тусгай сонирхлын аялал жуулчлалд ашиглах тээврийн хэрэгсэл худалдан авах санхүүжилтийг шийдвэрлэв.

МОНГОЛ, ХЯТАД, ОРОС ГУРВАН УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХАМТРАН АЖИЛЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТАЛЛАА 2025.11.07.

Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын Аялал жуулчлалын сайд нарын нэгдсэн хуралдааныг Дархан хотод зохион байгуулж, “Цайны зам” аялал жуулчлалыг хөгжүүлэх, дэд бүтцийг сайжруулах, туршлага солилцох зэрэг асуудлыг хэлэлцэн, хамтын ажиллагааны төлөвлөгөөнд гарын үсэг зурлаа. Энэ хүрээнд бүс нутгийн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх шинэ төслүүдийг хэрэгжүүлэхээр тохиролцов.

“ЦАЙНЫ ЗАМ” АВТО АЯЛЛЫГ НЭЭЖ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ШИНЭ БРЭНДИЙГ БИЙ БОЛГОЛОО 2025.11.08.

Гурван улсын хамтын ажиллагааны шинэ төсөл болох “Цайны зам” нэрэмжит авто аяллын маршрутыг албан ёсоор нээлээ. Энэ нь бүс нутгийн аялал жуулчлалын урсгалыг тогтворжуулах, соёлын харилцааг өргөжүүлэх, эдийн засгийн хамтын ажиллагааны шинэ гүүр болох стратегийн өндөр ач холбогдолтой үйл ажиллагаа юм.

“ИХ ТҮМЭН САНААЧИЛГЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЗӨВЛӨЛИЙН 16 ДУГААР УУЛЗАЛТ”-ЫГ УЛААНБААТАР ХОТНОО ЗОХИОН БАЙГУУЛЛАА 2025.12.10

“Их түмэн санаачилгын аялал жуулчлалын зөвлөлийн 16 дугаар уулзалт”-аар нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх, орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр гишүүн орнууд туршлага солилцлоо. Уулзалтад ОХУ, БНСУ, БНХАУ болон Монгол Улсын холбогдох яам, агентлаг, мэргэжлийн холбоодын төлөөлөл оролцож, хил дамнасан аялагчдын урсгалыг нэмэгдүүлэх, визийн зохицуулалтыг хөнгөвчлөх асуудлаар хэлэлцэв. Дараагийн 17 дугаар уулзалтыг БНХАУ-д зохион байгуулахаар шийдвэрлэлээ.

“МОНГОЛ УЛСАД 2026 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭГДСЭН ЦАГЛАВАР” БОЛОН “ӨВЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ”-Г ЗАСГИЙН ГАЗАРТ ТАНИЛЦУУЛЛАА 2025.12.24

Монгол Улсад 2026 онд зохион байгуулагдах соёл, аялал жуулчлал, спортын нийт арга хэмжээний нэгдсэн цаглаврыг нийслэл, 21 аймаг, мэргэжлийн холбоодын саналыг үндэслэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар батлууллаа. Мөн өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, улирлын хамаарлыг бууруулах зорилгоор үнийн хөнгөлөлт бүхий “Winter sale” аян зохион байгуулах, орон нутаг руу шууд нислэг хийх зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв.

МОНГОЛ УЛСАД 2026 ОНД БОЛОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭГДСЭН ХУАНЛИ
I УЛИРАЛ

1-р сар

Хэнтий аймгийн аварга шалгаруулах мөсөн шагайн тэмцээн	13-14	Хэнтий
"Мөнгөлөг шагшуурга" цас мөсний наадам	16-18	Ховд
"ARA winter" өвлийн наадам	16-18	Архангай
Онги-Улаан нуурын мөсний баяр	17	Өмнөговь
"Eruu Cap-2026" мөсөн сурын чуулга	17-18	Ерөө сум
Мөсөн сурын харваа	17	Баянхонгор
"Маанар" өвлийн эвент	17-19	Хөвсгөл
"Гүрэмийн мөнгөн талст" эвент	20	Хэнтий
Хар усан голын жавар	23-24	Баянхонгор
Тэмээн дээрээс наран ойрхон тэмээчдийн баяр	23-25	Дундговь
"Дархан цом" өвлийн мөсний загасчлал	24-25	Дархан-Уул
Өгий нуурын өвлийн наадам	30-31	Архангай
Улаанбаатар өвлийн наадам	31	Улаанбаатар

2-р сар

Улаанбаатар өвлийн наадам	1	Улаанбаатар
"Ахан дүүсийн наадгай" мөсөн шагайн харваа	1	Сэлэнгэ
Түмэн тэмээний баяр	6-8	Өмнөговь
"Тунгалаг толбо" мөсний баяр	7-8	Баян-Өлгий
Бурхантын өвлийн наадам / ICE Drift, Мөсний шагай, Мөсний сурын харваа, мөсний загасчлал/	7-8	Дархан-Уул
Өвлийн "Алтаргана" наадам	7-8	Дорнод
Их говийн тэмээ	7-8	Дорноговь
Тэмээний баяр	13	Хэнтий
Цаа, цасны баяр	27-28	Хөвсгөл
Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль	28-1	Улаанбаатар

3-р сар

Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль	28-1	Улаанбаатар
"Хөх сувд" мөсний баяр	2-4	Хөвсгөл
"Ээжийн чанасан цай" эвент	4-6	Сэлэнгэ
Бүргэдийн баяр	7-8	Улаанбаатар
Tourism week	9-15	Улаанбаатар
"Хөвсгөлийн цом" спорт загасчлалын тэмцээн	13-16	Хөвсгөл
Нүүдэлчдийн баяр	15	Баян-Өлгий
Түлек бүргэдийн баяр	21	Баян-Өлгий
Нарны баяр	22	Улаанбаатар
Радианы цом спорт загасчлалын тэмцээн	27-30	Хөвсгөл

MICE | Соёл, аялал жуулчлал | Спорт

МОНГОЛ УЛСАД 2026 ОНД БОЛОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭГДСЭН ХУАНЛИ
II УЛИРАЛ

4-р сар

Hospitality and Tourism International Expo 2026	3-4	Улаанбаатар
Horeca Mongolia Conference 2026	10	Улаанбаатар
Дархан тайж Хасарын нэрэмжит Төвийн бүсийн аварга шалгаруулах тэмцээн	11	Дархан-Уул
Оюутны спортын VII наадам		Улаанбаатар

5-р сар

Ул будгэрэх их өв	1-3	Дорнод
"Үндэсний бичиг, үсгийн баяр"	3	Улсын хэмжээнд
"Повер экспо" авто уралдаан	8-10	Улаанбаатар
Даль цэцгийн баяр	10	Хөвсгөл
"Үндэсний бичиг соёл, номын өдөр"	16-17	Улсын хэмжээнд
"Хаврын найраг" гэрэл зурагчдын өдөрлөг	16	Дундговь
Таеквондогийн Азийн АШТ	19-24	Улаанбаатар
"Хангинахын шугуйн шагайн тойром"	22-25	Булган
Сайханы сарлагийн баяр	23	Өмнөговь
"Улаанбаатар Трэйвел Экспо"	29-31	Улаанбаатар
"Дархан Марафон-2026"	30	Дархан-Уул
Бурхан багшийн их дүйчин өдөр	31	Улаанбаатар
"Артвийк" дурслэх урлагийн үзэсгэлэн		Улаанбаатар
"Шатрын Азийн" АШТ		Улаанбаатар

6-р сар

"Улаанбаатар Гранд Слам 2026" чөлөөт бөхийн тэмцээн	4-7	Улаанбаатар
Red fest nomadic motorcycle tour festival	5-6	Дархан-Уул
"Чингис мастер кросс" уралдаан	5-6	Дархан-Уул
"Талын Салхи" олон улсын мото наадам	6-7	Улаанбаатар
Азийн аялал жуулчлалын форум	11-13	Улаанбаатар
"Тэнгэр" бөөгийн наадам	12-15	Улаанбаатар
Тогорууны баяр	13-14	Хэнтий
Дархан хайрханы тахилга	15	Дархан-Уул
"Улаанбаатар Гранд Слам 2026" жудо бөхийн тэмцээн	19-21	Улаанбаатар
"Дэлхийн адууны өдөр" 10,000 морьтны парад ОУ-ын наадам	20-23	Өверхангай
Цайны замын нэрэмжит олон улсын авто ралли	20	
"Рэгги" хөгжмийн наадам	20	Улаанбаатар
Адуучин түмний соёл	21	Сэлэнгэ
"Алтаргана-2026" бага наадам	25-27	Сэлэнгэ
Хүүхдийн Хавдрын Олон Улсын Нийгэмлэгийн Ази тивийн салбарын 18 дахь удаагийн Их хурал /SIOP Asia 2026/	25-28	Улаанбаатар
Хөгжмийн наадам	26-27	Дундговь
"Хүрээ цам - Даншиг наадам"	27-28	Улаанбаатар
Хөгжмийн наадам	29-30	Өмнөговь
Улаанбаатарын яриа хэлэлцээ 11-р бага хурал		Улаанбаатар
Монгол Улс, БНХАУ-ын ӨМӨЗО-ны 6 дахь удаагийн хөрөнгө оруулалт, худалдааны форум		Улаанбаатар
"Фото Вийк"		Улсын хэмжээнд
"Монгол номадик" бэсрэг наадам		Улаанбаатар

MICE | Соёл, аялал жуулчлал | Спорт

МОНГОЛ УЛСАД 2026 ОНД БОЛОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭГДСЭН ХУАНЛИ
III УЛИРАЛ

7-р сар

"АРА" фестиваль	1-31 Архангай
Хэрлэнгийн баръяа	1-2 Дорнод
"Плэйтайм" хөгжмийн наадам	2-4 Улаанбаатар
"Цаатан" фестиваль	6-7 Хөвсгөл
"Дээлтэй Монгол" наадам	9 Улаанбаатар
"Говийн наран" наадам	10 Дундговь
Үндэсний их баяр наадам	10-13 Улаанбаатар
Хожуул Фестиваль	15-20 Завхан
Этник фестиваль-2026	15-18 Увс
"Хоймор" фестиваль	16-18 Сэлэнгэ
"Нүүдэлчин оршихуй" үндэсний урлагийн тоглолт	15-25 Өверхангай
"Арвагар хээр" адууны наадам	18-19 Өверхангай
"Монгол эсгий урлалын баяр"	22 Өверхангай
Сарлагийн баяр	23 Өверхангай
Алунгоо эхийн сургаалийн баяр	29-30 Хөвсгөл
"OECD Competition Law" ОУ-ын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын	Улаанбаатар
"Монгол номадик" бэсрэг наадам	Улаанбаатар

8-р сар

Тал нутгийн соёл	1-2 Дорнод
"Ойрад тумний язгуур-2026" ОУ-ын наадам	4 Увс
Орхоны хөндийн бяцхан 99 баатрын аялал	5 Архангай
"UB food" фестиваль	6-9 Улаанбаатар
Орхоны хөндийн адуучдын баяр	7 Архангай
"Айраг Фестиваль 2026"	7-8 Булган
Айрагны баяр	8 Архангай
Хүүхэд эрдэнэ	8 Дорнод
"Эрэмгий морьтон залуус" эвент	8 Хэнтий
"Морьт харваа" ОУ-ын уламжлалт харвааны наадам	8 Говьсүмбэр
"Өргөн Сэлэнгэ" амьд хөгжмийн наадам	8 Сэлэнгэ
"Торгоны зам-Хархорум хот" фестиваль	8-9 Өверхангай
"Хоёр нарны хооронд" олон улсын марафон	8-15 Хөвсгөл
Тарвасны баяр	14-16 Ховд
"Алтан элс" элсэн манхны баяр	14-16 Өмнөговь
"Адуучин 2026" аймгийн аварга шалгаруулах тэмцээн	15 Дархан-Уул
"Desert Storm" Олон улсын авто уралдаан	16-17 Өмнөговь
COP17 / НҮБ-ын цөлжилттэй тэмцэх конвенцын талуудын 17-р бага хурал/	17-28 Улаанбаатар
Golden Sand-2026	18-20 Увс
"Уяхан замбуу тивийн наран"	20-23 Дундговь
"Их хоёр загал" цагаан адууны баяр	21 Дундговь
Динозавр фестиваль	21-23 Өмнөговь
Олон улсын Монголч эрдэмтдийн XIII их хурал	21-24 Улаанбаатар
"Нүүдэлчин" дэлхийн соёлын фестиваль	22-24 Улаанбаатар
Монголын залуучуудын өдөр	25 Улаанбаатар
Улаанбаатар олон улсын явган алхалтын фестиваль	28-30 Улаанбаатар
Mining Week-2026 "Уул уурхайн долоо хоног" чуулга уулзалт, үзэсгэлэн	Улаанбаатар
Үндэсний спортын VIII наадам	Улаанбаатар
БНХАУ-ын Зүүн хойд азийн мужуудын бизнес уулзалт	Улаанбаатар
"Гонгорын бумбын тахилга"	Сэлэнгэ
БНСУ-ын КОТРА-тай хамтарсан экспортыг нэмэгдүүлэх арга	Улаанбаатар

9-р сар

"Эх хэлний өдөр"	1 Улсын хэмжээнд
Мянган морьтон фестиваль	5-6 Улаанбаатар
"Хиймор" морьт харвааны ОУ-ын тэмцээн	5-6 Улаанбаатар
Олон улсын фото зургийн наадам	5-10 Улаанбаатар
"Цамын хурал" шашин соёлын арга хэмжээ	8-9 Сэлэнгэ
Altay Nomad Games	12-13 Баян-Өлгий
"Адуу чи анд юм билээ" адууны өв соёл, айрагны баяр	15 Дундговь
Сагсай бүргэдийн баяр	17-18 Баян-Өлгий
"Тэнгэрийн хутагт" шашин, соёлын олон улсын эвент	18-19 Дорноговь
"Цайны зам-Жангар" наадам	18-20 Ховд
"Үндэсний бичиг соёл, номын өдөр"	19-20 Улсын хэмжээнд
Алтайн бүргэдийн баяр	21-22 Баян-Өлгий
"Утга зохиолын 7 хоног"	21-25 Улсын хэмжээнд
Алтанцөгц "Бүргэдийн Баяр"	26-27 Баян-Өлгий
"Майдар эргэх ёслол"	27 Говьсүмбэр

MICE | Соёл, аялал жуулчлал | Спорт

МОНГОЛ УЛСАД 2026 ОНД БОЛОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭГДСЭН ХУАНЛИ
IV УЛИРАЛ

10-р сар

"Талын гөрөөчин" тайга нохойн арга хэмжээ	3-4 Хэнтий
"Golden Eagle" бүргэдийн баяр	3-4 Баян-өлгий
Дархан хотын өдөр	15-16 Дархан-Уул
"Дархан дрифт" аварга шалгаруулах тэмцээн	18 Дархан-Уул
Аймгийн Засаг даргын нэрэмжит "Гал өд" яруу найргийн 25 дах наадам	22 Дархан-Уул
ITM-Mongolia ОУ-ын аялал жуулчлалын үзэсгэлэн	23-25 Улаанбаатар
"Жороон жороо" олон улсын бүжгийн наадам	28 Улаанбаатар
"Цайны замын түүх" олон улсын эрдэм шинжилгээний хурал	30

11-р сар

Horeca Mongolia Expo 2026	6-8 Улаанбаатар
"Аггана хүрээт" Монгол туургатны адуун соёлын их наадам	6-7 Сүхбаатар
Чингисийн хэрмийн хоног	7-8 Дорнод
Монгол бахархалын өдөр /Мялаалга наадам/	21 Хэнтий
"Болор цом" яруу найргийн наадам	26 Улаанбаатар
Иргэний андгай өргөх ёслол	26 Улаанбаатар
Талын түмэн адуу	21-22 Хэнтий
Тэмээний баяр	28-29 Увс

12-р сар

Khurkhree ice festival	5-6 Өверхангай
Ламын гэгээний улаан тэмээний баяр	15-16 Баянхонгор
“Мөнгөн өвөл”	31 Дархан-Уул

2026 ОНД БОЛОХ АРГА ХЭМЖЭЭ

"Монгол-Сингапур"-ын "Хот байгуулалт, орон сууцжуулалтын хөгжил" хамтын ажиллагааны чуулган	Улаанбаатар
төв азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа /CAREC/ -ны хөтөлбөрийн аялал жуулчлалын салбарын хурал	Монгол улс
төв азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа /CAREC/ -ны хөтөлбөрийн сайд нарын хурал	Монгол улс
Их түмэн санаачилга бүс нутгийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн Сайд нарын бага хурал	Монгол улс
Бэлчээр ба нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн олон улсын жилийг тэмдэглэх	Монгол улс

MICE | Соёл, аялал жуулчлал | Спорт

МОНГОЛ УЛСАД ЗОЧИЛСОН ГАДААДЫН АЯЛАГЧДЫН ТОО ТҮҮХЭН ДЭЭД АМЖИЛТЫГ ҮЗҮҮЛЛЭЭ 2025.12.25

Монгол Улсад 2025 оны эцсийн байдлаар 854,235 жуулчин хүрэлцэн ирсэн нь өмнөх жилүүдийнхээс өсөж, түүхэн дээд хэмжээнд хүрлээ. Аялал жуулчлалын салбарын орлого 1.6 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд жуулчдын тоо өмнөх оны мөн үеэс 14 хувиар өссөн байна. Үүнээс тухайлбал, БНХАУ-аас 15,604, ОХУ-аас 13,260, БНСУ-аас 2,905 жуулчин тус тус иржээ. ССАЖЗЯ-наас хэрэгжүүлж буй бодлогын үр дүнд жуулчдын урсгал цаашид ч тогтмол өсөх хандлагатай байна.

15,604
ЖУУЛЧИН

13,260
ЖУУЛЧИН

2,905
ЖУУЛЧИН

2025 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРИЙН БАЙДЛААР

ЖУУЛЧИН 854,235

ХАРИУЦЛАГАТАЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХЭЭР “УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БҮС”-ИЙГ 12 АЙМГИЙН 17 БАЙРШИЛД ТОГТООН БАТАЛЛАА 2025.12.31

Байгаль орчинд сөрөг нөлөөгүй, тогтвортой хөгжлийн бодлогод нийцсэн хариуцлагатай аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор эдийн засгийн 6 бүсийн 12 аймгийн 17 байршилд “Улсын аялал жуулчлалын бүс”-ийг тогтоон Засгийн газрын хуралдаанаар баталлаа. Эдгээр бүсийн менежментийн төлөвлөгөөг үе шаттай хэрэгжүүлж, дотоод гадаадын хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээлээр дэмжих замаар дөрвөн улирлын аяллыг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүллээ.

TRAVEL PLATFORM ХӨГЖҮҮЛЭЛТ

Дэлхий даяар жуулчдын 60% нь аяллаа онлайн орчинд захиалж, 94% нь аяллын үеэрээ гар утсаа идэвхтэй ашигладаг. Манай орны хувьд шинэ өдөр тутмын хэрэглээтэй жуулчдын хувьд төдийлөн эзлтэй орны тоонд багтдаггүй. Дэлхийн банкны Ухаалаг засаг 2 төслийн хүрээнд Travel Platform цогц систем хийгдэхээр 2023 онд батлагдсан. Гэвч энэхүү платформын мэргэжлийн болон техникийн шаардлагыг тодорхойлох ажил 2 жил хагас гацсан байсныг эрчимжүүлэн батлууллаа.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛИЙГ ТОГТООХ, ОЛГОХ, БУУРУУЛАХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХТОЙ ХОЛБООТОЙ ЖУРМЫГ ШИНЭЧЛЭН БАТАЛЛАА 2026.01.07

Жуулчдын хэрэгцээ, шаардлагад нийцэн хурдацтай өөрчлөгдөж буй зочлох үйлчилгээний салбарыг бид өмнө нь 2008 оны стандарт, 2009 оны журмаар зохицуулж, 474 шалгуурыг хангахыг байгууллагаас шаарддаг байсан. Харин шинэчлэгдсэн журмыг олон улсын жишгийн дагуу боловсруулан батлуулсан ба зэрэглэл олгох процесст төрийн оролцоо багасаж, байгууллага сайн дурын үндсэн дээр зэрэглэл тогтоолгох нөхцөл бүрдлээ. Бид дэлхийн олон орны жуулчдад үйлчилгээ үзүүлэхдээ олон улсын үйлчилгээний жишиг, стандарттай нийцүүлэн аялал жуулчлалаа хөгжүүлэх нь зүйтэй юм.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН СУРГАЛТЫН ТӨВ

Салбарын хүний нөөцийн хэрэгцээ өндөр энэ цаг үед Монгол Улс, БНСУ-ын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны хүрээнд Аялал жуулчлалын сургалтын төвийн барилгыг хүлээн аваад байна. Цаашдаа тус Сургалтын төвийн барилгыг түшиглэн Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага буюу бидний хэлж заншсанаар МСҮТ-ыг албан ёсоор байгуулахаар боллоо.



ШУУД НИСЛЭГТЭЙ ГАЗРЫН ТОО НЭМЭГДЭВ

Монголд зочлон ирж буй жуулчдын 52% нь агаарын тээврээр хүрэлцэн ирдэг ба тус салбар нь манай аялал жуулчлалын хөгжилд шууд нөлөөллийг үзүүлдэг билээ. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд агаарын тээврийн салбар амжилттай ажиллаж Шанхай, Сингапурын чиглэлд Үндэсний агаарын тээвэрлэгч компани тогтмол нислэг эхлэн, АНУ-ын Юнайтед Эйрлайнс, БНХАУ-ын Спринг эйрлайнс компаниуд манай орон руу нислэг эхлүүллээ. 2025 онд агаарын тээврийн салбар 2.4 сая зорчигч тээвэрлэсэн ба энэ нь өмнөх онтой харьцуулахад 14% өссөн байна.

ХӨВСГӨЛ АЙМАГ ОЛОН УЛСЫН ШУУД НИСЛЭГ ХҮЛЭЭН АВЛАА. 2025.07сар

БНСУ-ын Чонжугаас Хөвсгөл аймгийн Мөрөн хотын нисэх буудалд анхны шууд нислэг газардсан юм. Зөвхөн Улаанбаатар хотоор дамжин ирдэг байсан жуулчдын хувьд өөрийн аялахыг хүссэн газартаа шууд нислэгээр очих боломж ийнхүү бүрдсэн нь манай орны аялал жуулчлалын салбар төдийгүй зам тээврийн салбарт чухал алхам болсон.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТӨСӨЛ ХӨГЖҮҮЛЭЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ЭРЧИМЖҮҮЛЭВ 2026.03 сар

Жуулчны бааз, зочид буудал барих үйл явцыг хөнгөвчлөх, стандарт шаардлагыг сайжруулах зорилгоор төслийн загвар, санхүүгийн нарийвчилсан тооцооллын жишгүүдийг боловсруулан аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг үзүүлж, энэ чиглэлд төр, хувийн хэвшлийн түншлэлийг идэвхжүүллээ.

IV.5 ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР

ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ АСУУДЛААР УИХ ДАХЬ НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ШИЙДВЭР ГАРГАЛАА 2025.07.09

УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилттэй танилцах, дүгнэлт гаргах ажлын хэсэг холбогдох талуудтай цуврал уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, олон улсын туршлага, хуулийн үр дагаварт үнэлгээ хийлээ. Үүний үр дүнд УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооны 2025 оны 10 дугаар тогтоол гарч, Засгийн газарт чиглэл өгөгдөн хэрэгжилтийг хангаж байна.

ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ТҮНШЛЭЛ: САЛБАР ДУНДЫН УЯЛДАА ХОЛБОО ЧУУЛГАН ЗОХИОН БАЙГУУЛАВ 2025.10.20

Залуучуудын өмнө тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, шийдвэрлэхэд салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор ССАЖЗЯ-наас Төрийн ордонд уг чуулганыг зохион байгууллаа. Чуулганы өмнө 12 яамны 423 албан хаагч болон 4 бүсийн орон нутгийн залуучуудын дунд урьдчилсан хэлэлцүүлэг өрнүүлж, гарсан саналуудыг нэгтгэн чуулганы үеэр танилцуулсан бөгөөд олон улсын болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран боловсруулсан нэгдсэн зөвлөмжийг Монгол Улсын Ерөнхий сайдад хүлээлгэн өгөв.

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ АНДГАЙ ӨРГӨХ ЁСЛОЛ 2025.11.26

Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор 23 дахь жилдээ зохион байгуулагдаж буй "Иргэний андгай өргөх ёслол"-ыг ССАЖЗЯ, Монголын Залуучуудын Холбоо хамтран амжилттай зохион байгууллаа. Нийслэл хотод Төрийн ордонд 871 сурагч, харин 21 аймгийн хэмжээнд 4,607 хүүхэд оролцож, Монгол Улсын иргэний андгайгаа өргөлөө.

МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛД ЗАЛУУЧУУДЫН АСУУДЛЫГ ТУСГАВ 2025.11.28

Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/13 дугаар тушаалын дагуу “Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл”-ийн төсөлд залуучуудын хөгжлийг дэмжих хүрээнд салбарын 1 үр дүн, 2 хөтөлбөр арга хэмжээг тусгуулан батлууллаа. ССАЖЗЯ-наас холбогдох яамдтай хамтран 2027 он гэхэд Залуучуудын хөгжлийн индексийг 5 байраар урагшлуулж, дэлхийд 59 дүгээрт эрэмбэлэгдэх зорилт тавин ажиллаж байна. Мөн хоёр жил тутамд “Монголын залуучуудын хөгжлийн тайлан”-г эмхэтгэн гаргахаар төлөвлөлөө.

ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛЛАА 2025.12.30

Улсын хэмжээнд 21 аймаг, 9 дүүрэг, 12 яамны залуучуудыг хамруулсан нийт 33 удаагийн хэлэлцүүлэг, арга хэмжээг зохион байгуулж, 2,583 залуусын саналыг сонслоо. Эдгээр санал, зөвлөмж болон 13 төрлийн судалгааны үр дүнд үндэслэн Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал, төслийг бүрэн боловсруулж дууслаа.

IV.5 ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

УИХ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Ч.Ундрам нь тус хорооны гишүүдийн хамтаар Бүгд Найрамдах Чех Улс (БНЧУ) болон Бүгд Найрамдах Франц Улсад (БНФУ) ажлын айлчлал хийж, боловсрол, соёлын харилцааг өргөжүүлэх чиглэлээр олон талт уулзалтуудыг амжилттай зохион байгууллаа.

БНЧУ-д хийсэн айлчлалын хүрээнд:

- Карлын Их сургуулийн удирдлагуудтай уулзаж, их дээд сургуулиудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, “Илгээлт-2100” тэтгэлэгт хөтөлбөрийн хэрэгжилт болон монгол судлалыг дэмжих асуудлаар санал солилцов.
- Чех Улсын Төлөөлөгчдийн танхимын гишүүн, Чех-Монголын Парламентын бүлгийн удирдлагуудтай уулзан, Чехийн Үндэсний музейд зохион байгуулагдаж буй “Чингис хаан” олон улсын үзэсгэлэнгийн үйл ажиллагаатай танилцлаа.
- Монгол Улсаас БНЧУ-д суугаа Элчин сайдын яаманд зочилж, тус улсад амьдарч буй монгол хүүхдүүдэд зориулсан хэл, соёлын төв байгуулах болон иргэдийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн асуудлаар ярилцлаа.

БНФУ-д хийсэн айлчлалын хүрээнд:
(Дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойн жил):

- БНФУ-ын Сенатын ээлжит чуулганы хуралдааны үйл ажиллагаатай танилцаж, Сенатын гишүүн, Франц-Монголын парламентын бүлгийн дарга Филипп Мүэйтэй уулзан, 2026 оныг “Боловсролыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан хамтын ажиллагааг эрчимжүүлэхээр тохиролцлоо.
- Францын соёлын бодлогын томоохон хөтөлбөр болох “Pass Culture” байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, залуу үеийнхэнд соёл, урлагийг хүртээмжтэй хүргэх туршлагыг судаллаа.
- Луврын музей болон Францын Үндэсний номын санд зочилж, соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын чиглэлээр туршлага солилцов.

Энэхүү айлчлал нь хоёр улсын парламент хоорондын харилцан итгэлцлийг нэмэгдүүлэх, боловсрол, соёлын салбарын шинэчлэлд олон улсын сайн уршлагыг нэвтрүүлэх чухал ач холбогдолтой үйл явдал боллоо.

“ЧИНГИС ХААНЫ УР ХОЙЧИС” ҮЗЭСГЭЛЭН БОЛОН ВЕНЕЦИЙН БИЕННАЛЬД ОРОЛЦОХ БЭЛТГЭЛИЙГ ХАНГАЛАА 2026.03.24-27

ОХУ-ын Москва хотноо “Чингис хааны үр хойчис” сэдэвт түүхэн үзэсгэлэнг амжилттай зохион байгуулж, хэвлэл мэдээллийн нэгдсэн төлөвлөгөөгөөр сурталчилсан.



Мөн олон улсын дүрслэх урлагийн хамгийн том наадам болох Венецийн биеннальд Монголын соёл, урлагийг дэлхийн тавцанд сурталчлах алхмуудыг амжилттай хэрэгжүүлэв.

“МОНГОЛЫН САЙХАН ОРОН” ТОГЛОЛТ ДЭЛХИЙН УЛС ОРНУУДАД ТОГЛОЖ, ҮНДЭСНИЙ УРЛАГАА СУРТАЛЧИЛЛАА

Монгол Улсын ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн олон улсад хийсэн төрийн айлчлалын хүрээнд “Монголын сайхан орон” урлагийн тоглолт болон гэрэл зургийн үзэсгэлэнг Турк, Чех, Польш, Киргиз, Тажикстан, Энэтхэг, Итали болон Гэгээн ширээт улсуудад тус тус зохион байгууллаа. Тус арга хэмжээнд Монгол Улсаа төлөөлж Монголын Үндэсний урлагийн их театрын Үндэсний их найрал хөгжим бүрэн бүрэлдэхүүнээрээ болон Монгол Улсын филармонийн Морин хуурын чуулгын нийт уран бүтээлчид оролцон үндэсний урлагийн шилдэг дээжис, урын сангаас толилуулж, үндэсний урлагаа таниулж, эх орноо сурталчиллаа.

THANK YOU

МИНИЙ АЖЛЫН ТАЙЛАНТАЙ
ТАНИЛЦСАН ТАНД БАЯРЛАЛАА